

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-42

1.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх	14-27
2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	27-35
3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	35-42

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
06 дугаар сарын 25-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 00 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Л.Мөнхбаатар.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хэлэлцэх асуудлын 4 дүгээрт орсон “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлаас хасах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 8

Бүгд: 13

38.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр танилцуулав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Б.Энхбаяр, Н.Алтанхуяг, Б.Пүрэвдорж, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийг долоо хоногоор хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хэлэлцэх асуудлын дарааллын 2 болон 3-т орсон асуудлуудын дарааллыг өөрчилж, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг дарааллын 3 дугаарт оруулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.8 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хоёр.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Сандаг, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, мөн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн холбооны дарга Т.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Ц.Сандаг-Очир: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “танилцуулж, төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг хасаж, мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчид хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хавтаст хэргийн материал танилцуулах хугацаа 7 хүртэл хоногт, бусад хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн холбооны дарга Т.Энхбаяр, Монголын Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал/

Ц.Сандаг-Очир: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтад анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн болон гүйцээн боловсруулах чиглэл авсан саналыг тусган, доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмэх:

“17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

17.3.2.ялгаварлан гадуурхахгүй байх;

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар буюу гуравны хоёроор дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтад анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн болон гүйцээн боловсруулах чиглэл авсан саналыг тусган, доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмэх:

“17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

17.3.2.ялгаварлан гадуурхахгүй байх;

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар буюу гуравны хоёроор дэмжигдлээ.

/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлээр ажилладаг хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.3.6.асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.6.Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой хувилбарыг, үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Ц.Сандаг-Очир: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэсний өмнө “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө “33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-д” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж,” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, “40 дүгээр зүйлийн” гэсний өмнө “39.4 дэх хэсгийн “39.3-д” гэснийг “39.3, 39.4-т” гэж,” гэж 5 дугаар зүйлийн “12.2.1,” гэсний дараа “12.2.17” гэж, мөн төсөлд **“6 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 70.6 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “39.3” гэсний дараа “, 39.4” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “энэ хуулийн 41.3” гэсний дараа “, 41.4” гэж,” гэснийг 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэснийг “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж хавсаргана” гэж,” гэснийг, “мөн зүйлийн 41.4, 41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10 дахь хэсгийн дугаарыг “41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10, 41.11” гэж, 41.5 дахь хэсгийн “41.4-т” гэснийг “41.5-д” гэж, 41.7 дахь хэсгийн “41.5-д” гэснийг “41.6-д” гэж,” гэснийг, мөн зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг, 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2,17, 12.2.24 дэх заалтыг,” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 00 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Ц.Сандан-Очир: Эрхэм гишүүдээ Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 6 сарын 25-ны өдрийн Байнгын хорооны хуралдаан ирц үүссэн байна. Хуралдаа ирэхийг хүсэж байна. Одоогийн байдлаар ирсэн гишүүдийг танилцуулъя. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Сайнзориг гишүүн ирсэн байна, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн байна, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн ирсэн байна, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна, Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна, Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирц 45 хувьтай байна. Ирээгүй гишүүдийг танилцуулъя. Жуковын Алдаржавхлан гишүүн ирээгүй байна, Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирээгүй байна, Батжаргалын Заяабал гишүүн ирээгүй байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирээгүй байна, Норовын Алтанхуяг гишүүн ирээгүй байна, Халтмаагийн Баттулга гишүүн ирээгүй байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирээгүй байна, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирээгүй байна, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирээгүй байна, Дашдондогийн Ганбат гишүүн ирээгүй байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирээгүй байна. Хурдан гишүүдээ дуудаарай, 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай тул бид нар гуравхан цагийн дотор хуралдах эрхтэй байна. 11 цагаас хуралдах ёстой байсан хурал одоо 11 цаг 41 минут болж байна.

ХЗБХ-ны эрхэм гишүүдээ өдрийн мэнд хүргэе. 2025 оны 6 сарын 25-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Байнгын хорооны дарга өнөөдөр чөлөөтэй байгаа учраас миний бие хуралдааныг даргалж явуулах юм байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Одоогийн байдлаар чуулганы хуралдаанд Норовын Алтанхуяг гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд ирсэн. Хуралдааны ирц 54,5 хувьтай байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төсөл. 2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 1 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. 3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. 4Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Энхбаяр гишүүн, Тэмүүжин гишүүн, Сайнзориг гишүүн. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдийнхээ амгаланг айлтгая. Хэлэлцэх асуудлын 4-д байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан илтгэлийг дагаж гарах ажлын хэсэг хуралдаагүй байгаа. Бид өнөөдөр ажлын хэсгийн гишүүддээ тогтоолынхоо төслийг хүргүүлсэн. Ажлын хэсгийн гишүүд маань зарчмын саналууд гаргаж байгаа. Тэгэхээр тэр саналуудыг ярилцах үүднээс энэ асуудлыг хойшлуулж өгөөч гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Өнөөдрийн мэндийг хүргэе. Энэ хэлэлцэх эсэх, хэлэлцэх асуудал дээр байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал хураах гэж байна. Улсын Их Хурлын чуулган дээрээс боловсруулахаар буцаагаад өгсөн зүйл, заалт хасагдаад ороод ирж байна. Чуулганы хуралдаан дээр санал хураалгалгүйгээр эцэслэн боловсруулах чиглэл авъя гэж хэлчхээд, тэгээд эцэслэн боловсруулах тэр чиглэл дээр энд болохоор ингээд огт байхгүй, санал хураалт байхгүй, хасаад ороод ирж байна Ажлын хэсэг дээр. Тийм учраас яг тэр асуудал шийдэгдээгүй байгаа учраас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх хэлэлцүүлгээс асуудлыг энэ Байнгын хорооноос хасах саналтай байна.

Асуудал нь юу байсан бэ гэхээр эрүү шүүлт хэрэглэж авсан мэдүүлэг болон бусад нотлох баримтыг хэрвээ эрүү шүүлт авсан нь тогтоогдвол хүчингүй болохоос гадна, эрүү шүүлтэд өртсөн тэр нотлох баримтын эх сурвалжийг өөрийг нь яллах талын эх сурвалж болохгүй байх тухай заалт байхгүй юу. Энэ Вишинскийн онол гэж ярьдаг, хүн нь байвал хэрэг нь олдоно гэдэг зарчим. Зөвхөн хэрэгт шалгагдаж байгаа хүнийг өөрөөр нь хэргийг нь нотлуулах гэж оролддог энэ уламжлалт мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн шалгах гэж нэрлэж болохгүй байх. Мөрдөн байцаах ажиллагааг Монгол Улсын хувьд зогсоох гол зохицуулалт байхгүй юу, заалт байхгүй юу. Бид эрүү шүүлттэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын маш олон илтгэлийг сонссон. Олон улсад амласан амлалттай холбоотой нэгдэж орсон гэрээтэй холбоотой хийх ажил маш их байгаа. Гэтэл энэ асуудал дээрээ жоохон зориг гаргаад шийдчихэж чадахгүй, тэгээд дэгийн бус байдлаар ингэж орж ирж байгаа энэ асуудлыг хасах саналтай байна хэлэлцэх асуудлаас.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Саяын ч хууль дээр яах вэ тэгээд хураалгах үе дээр нь би ажлын хэсгийн гишүүний хувьд яаж ажилласан, ямар байдлаар орж ирж байгаа тайлбар өгч болно гэдэг зүйлийг би хурал даргалагч хүнд хэлье. Тэмүүжин

гишүүний хэлж байгааг бид хэд ерөөсөө үгүйсгээгүй. Уг нь дэмжээд байгаа, хамтраад цаашдаа энэ асуудлыг илүү нарийн тусгая л гэдэг байдалтай байгаа. Одоо хураалгачихъя гэхээр бусад заалтуудтай зөрчилдчих гээд байгаа юм. Тэгээд үзэл баримтлалын хүрээнд хөндөгдөж орж ирээгүй юмыг бид хэд хийж болох юм уу, үгүй юу гэдэг л юм байсан юм.

Миний гол асуудал Хууль тогтоомжийн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль дээр одоо нэг ийм зүйл гарах гэж байна л даа. Гүйцээн боловсруулах гэдэг бол парламентаас хураагаагүй санал. Гэтэл парламент хураагаад, ХЗБХ-ны дэмжээгүй саналыг дэмжье гэж хураагаад тэр санал дэмжигдээгүй буюу миний гаргасан санал уг нь туссан. 17.3 дугаар зүйлийг хасъя гээд орж ирэх санал дэмжигдчихээд, парламент дээр дэмжигдчихээд байхад энэ дээр эцсийн хэлэлцүүлэг дээр хасаагүй. Яагаад гэхээр бид 17.3-ын энэ бусад хэсэг дээр гүйцээн боловсруулах чиглэл авсан учраас энэ саналыг чинь тусгахгүй. Би ерөөсөө энэ 1, 1 заалт дээр нь хэлээгүй байхгүй юу. Бүхэлд нь хасъя гээд санал дэмжигдчихээд байхад миний саналыг тусгахгүй мөртөө энэ саналыг бид гүйцээн боловсруулах гэж байгаа юм гээд ингээд яриад, би ийм байж болох юм уу? Энэ чинь олонх нь энэ 10, Хууль тогтоомжийн хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг хасъя гээд шийдчихээд байхад хасахгүй, эцсийн хэлэлцүүлгээр тусгаж орж ирэхгүй гээд анхны хэлэлцүүлгээр парламентад шийдчихсэн саналыг тусгаж орж ирэхгүй энэ материалыг гишүүдэд тарааж байна шүү дээ. Мэдэхгүй, харин энэ дээр тайлбар авъя.

Байхгүй шүү дээ, нэг нь гүйцээн боловсруулах гэдэг юмыг барьж болох боловч энэ нөгөө саналаараа хураагдаад хасагдчихаад байхад, харин тийм. Тэгэхээр ийм нөгөө бэлэн бус юмыг хэлэлцэж болох юм уу? Би Байнгын хорооны хувьд нөгөө дэг сахиулж байгаа Дэгийн ерөнхий зөвлөх Улсын Их Хурлын Тамгын газрын дарга Баасандорж дарга нэг хэлээд мухарлахгүй бол би зүгээр ойлгохгүй байна. Гүйцээн боловсруулах чиглэл авсан учраас ингүүтээ чуулганаар дэмжигдсэн саналыг тусгахгүй орж ирнэ гэдэг ер нь тэгээд хүнд нь тааруулж яриад л байх шиг байна даа гэж л хэлье дээ.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг дарга таныхыг горимын санал гэж үзэх юм уу? Сайнзориг гишүүнээ горимын саналаа яг гарга хэлэлцэх асуудалтай холбогдуулж.

П.Сайнзориг: Би энэ дээр зүгээр байна шүү дээ гол асуудал нь ийм байгаа. Би парламентынхаа гишүүдийн олонхын саналыг хүндэтгэж байгаа. Анхны хэлэлцүүлэг дээр саналууд гаргаад, дэмжигдээд, дэмжигдэхгүй гээд 2 байдалтай явсан. Ядаж дэмжигдсэн энэ саналыг нь парламент дэмжиж өгсөн энэ саналыг нь энэ дээр эцсийн хэлэлцүүлэгт тусгаж орж ирж өгөөч л гэж хүсэж байгаа юм. Одоо энэ эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж байгаа төсөл чинь өөрөө энэ саналыг тусгаагүй учраас Үндсэн хууль зөрчих гээд байна. Би бусад саналуудыг хүндэтгэж байгаа шүү дээ. Мэтгэлцээд, маргаан гарсан байж магадгүй. Би Улсын Их Хурлын шийдсэн олонхын саналаар шийдэж байгаа саналыг хүндэтгэж байгаа. Гэтэл Улсын Их Хурлаас олонх нь шийдээд энэ заалтыг хас гэххээд байхад хасахгүй гээд байдаг. Чи Энхтүвшиний саналуудыг ер нь гишүүд ч юм уу, Жаргалан гишүүний санал дээр байр сууриа илэрхийлээд гүйцээн боловсруулах чиглэл авчихсан шүү дээ. Парламент анхны хэлэлцүүлгээр олонхоор шийдчихээд байхад яагаад ийм зүйл ингээд дэмжигдсэн санал.../үг тасрав/

Ц.Сандаг-Очир: Тэгээд горимын санал гаргая.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ асуудлуудыг энэ зөв болтол нь хойшлуулж өгөөч л гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Номинчимэг гишүүн, өгнө, өгнө.

О.Номинчимэг: Энэ дэгийг их буруу тайлбарлаад их гуйвуулж байна. Тэгээд энэ удаа дараа ажиглагдаж байна Сайнзориг гишүүнээ. Энэ нэгдсэн чуулган дээр юу болсон гэхээр 17.3-тай холбоотой энэ асуудал ерөөсөө чиглэл авсан юм. Энэ гүйцээн боловсруулахаар нарийвчилж үг, үсэг дээр нь яах ёстой гэдэг энэ чиглэлээр чиглэл авсан. Таны саналаас гадна Жаргалан гишүүн, Энхтүвшин гишүүн 17.3-тай холбоотой санал гарсан. Энэ гишүүд 17.3-ыг байх ёстой. Гэхдээ үг, үсгийн хувьд энийг нь нэг харах ёстой гэсэн санал байхгүй юу. Тэгэхээр таны саналыг парламент дэмжсэн, нөгөө хүмүүсийн саналыг парламент дэмжээгүй юм шиг ярьж болохгүй. 17.3-тай холбоотой ингээд бүхэлд нь харах 3, 4 саналыг энэ чинь ингээд зөрчилтэй, хоорондоо зөрчилтэй асуудал байгаа болохоор ажлын хэсэг энийгээ хараад, тэгээд саналаа оруулж ирж байгаа. Тэгээд та зөвхөн парламентын дэмжсэн санал биш, цаана чинь дахиад ажлын хэсгийн санал, дахиад Жаргалан болон Энхтүвшин гишүүдийн санал байгаа гэдгийг анхаараарай. Ингээд яаж байгаа. Тэгээд дэгийн хувьд илүү бүүр нарийвчилж хагалах ёстой юм байвал Тамгын газар энэ дээр тайлбар хийчих хэрэгтэй.

Ц.Сандаг-Очир: Саналаа хураая. 3 горимын санал гарсан. 3 горимын саналаар санал хураая. Нэгд Энхбаяр гишүүний гаргасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг хуралдаж амжаагүй байгаа юм байна. Тийм учраас энэ асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасаж өгөөч гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй, бэлдсэн үү? Горимын саналыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн, 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар санал дэмжигдлээ. 4 дэх асуудлыг хойшлууллаа.

Горимын 2 дахь санал. Тэмүүжин гишүүний гаргасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Монгол Улсын ЗГ-аас 24 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. Энэ асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн томьёоллын дэмжье гэсэн томьёоллоор гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдээрэй, бэлтгэгдчихсэн байгаа юу? Саяынхаар. 13 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 46,2 хувиар санал дэмжигдсэнгүй тул 3 дахь хэлэлцэх асуудал хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орлоо.

3 дахь горимын санал. Сайнзориг гишүүний гаргасан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүний 25 оны 1 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлаас хойшлуулж өгөх тухай горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 13 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 38,5 хувиар горимын

санал дэмжигдсэнгүй. Өнөөдрийн хэлэлцэх асуудалд орлоо. Ингээд хэлэлцэх асуудлууд батлагдлаа.

Нэг.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэх асуудалдаа оръё. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийг хэлэлцье. Алив ажлын хэсгийг. Өөрөө бол тухайн үедээ л яачихъя тэгэх үү. Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Комиссын 26 оны төсвийн асуудал хэлэлцэхэд оролцох албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын дээд шүүхээс С.Заяадэлгэр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Д.Эрдэнэчимэг Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал, А.Эрдэнэцэцэг Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч.

Улсын Дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан танилцуулгыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр танилцуулна. Заяадэлгэр даргын микрофон ажлын хэсгийн хэд вэ? 3 дахь микрофоныг өгье. Хажууд чинь гараад байна даа асаад, 2 дахь микрофон чинь асаад байна. Ажлын хэсгийн 3 дахь микрофон гэсэн шүү дээ уг нь.

С.Заяадэлгэр: Сайн байцгаана уу, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын дээд шүүхийн 26 оны төсвийн товч танилцуулгыг хийе. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар улсын төсвөөс шүүх санхүүжих, шүүхийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгааг хангах, Шүүхийн хуульд заасан мөн шүүхийн хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх, бие даасан төсөвтэй байх, мөн төсвийг ХЗБХ-гоор хянан нэгтгүүлэх зэрэг холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн 26 оны төсвийг бат боловсруулсан. 26 оны төсвийг бид боловсруулахдаа 24 онд батлагдсан Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, мөн Алсын хараа 2050, мөн Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн захирамжаар батлагдсан Дээд шүүхийн стратеги төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд 2006 онд хийж, хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээг хэмжээн дээр үндэслэсэн байгаа.

Шүүхийн тухай хууль 2021 онд шинэчлэн батлагдаж үүнээс хойш 2023, 2024 онуудад зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсон. Энэ хүрээнд Улсын Дээд шүүхийн хяналтаар шийдвэрлэх хэргийн цар хүрээг нэмэгдүүлснээс гадна шүүхийн ил тод, хараат бус байдлыг хангах, энэ хүрээнд хяналтын шатны бүх шүүх хуралдаанууд нээлттэй шууд дамжуулагддаг байх, мөн шүүхийн цахимжилт, хэргийн хөдөлгөөний системүүдийг нэгдсэн ийм төвлөрсөн системтэй болгох зэрэг ийм хуульд орсон өөрчлөлтүүдийн дагуу бид бүхэн үе шат дараатай ажлыг төлөвлөн ажиллаж байна.

24 онд Улсын дээд шүүх 3021 хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх оноос 6,3 хувиар өссөн байна. Улсын Дээд шүүх өнгөрсөн онд зорилтот түвшнээ 25 оны зорилтот түвшнээ хугацаандаа шийдвэрлэсэн хэргийн хувийг 93 хувьд хүргэнэ гэж төлөвлөж байсан бол энэ жил 94 хувьтай гарсан байгаа. Улсын хэмжээнд энэ хувь 92,7 хувьтай байдаг хугацаандаа шийдвэрлэсэн хэргийн. Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн

хуралдаанаас хуралдаан өнгөрсөн жил 12 удаа хуралдаж, 50 асуудлыг хэлэлцсэн. Эдгээрээс 8 хуулийн санал хууль тогтоомжийг боловсронгуй болох төслийг төслийн саналыг хэлэлцсэн. Мөн шүүхийн үйл ажиллагаанд мөрдөгдөх аргачлал журмуудыг баталсан байна.

Улсын Дээд шүүхийн дэргэд Шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн хэрэгцээ судалгаанд тулгуурлан шүүгч бэлтгэх болон шүүгч мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулдаг. Мөн нийт шүүхийг шаардлагатай судалгаа мэдээллээр хангаж ажилладаг академи байгуулагдсан. Академийн үйл ажиллагаа 24 оны хуулиар өргөжсөнтэй холбоотойгоор энэ 26 оны төсөв дээр зохих өөрчлөлтүүд мөн орж ирж байгаа. Энэ төсөв 16, өмнөх оноос 16,9 хувиар өсөж байгаа нь шинээр байгуулагдах гэр бүл, хүүхдийн шүүхтэй холбоотой шүүгчдийг сургах сургалтууд, саяын түрүүн дурдагдсан хуулийн өөрчлөлтүүдтэй холбоотой сургалтууд нэмэгдэж тусгагдаж байгаатай холбоотой.

Цалин, нийгмийн даатгал бол холбогдох тогтоол шийдвэрийн дагуу хуульд өөрчлөлт ороод Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон цалин урамшуулал олгох журам зааврын дагуу ирэх оны төсвийг төсөвлөн орж ирсэн. Ер нь онцлох төсвийн асуудал бол бид бүхэн Улсын дээд шүүх дээр цахим виртуал шүүгчийн туслах төслийг хэрэгжүүлж, шүүгчийн судалгаа шинжилгээний ажлыг илүү өргөн хүрээтэй мэдээллийн технологи ашиглаж хүртээмжтэй болгох үүднээс шүүгчийн судлаач туслахын орон тоог 21 оны хуулиар тусгагдаж орж ирсэн боловч 7 удаа нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад шүүгчийн туслахын орон тоо хангагдахгүй, шалгуур хангах хуульчид тэр болгон төдийлөн олдохгүй байгаатай холбоотой энэ цалин орон тоо бол хэмнэгдээд явдаг. Өнгөрсөн жил энэ тал дээр цалингийн хэмнэлт гарч бид 900 гаруй сая төгрөгийн цалинг улсын төсөвт эргүүлэн буцаан тушаасан байгаа. Энэ орон тооны хийдлийг цаашид нөхөхийн тулд, тэгээд энэ ажлын чанар, үр нөлөөгөө сайжруулахын тулд хиймэл оюун ухааныг Улсын Дээд шүүхийн энэ хэргийн судалгаанд ашиглая. Үүн дээр өнгөрсөн оноос бид дэд бүтцээ суурь судалгаануудаа хийх энэ цар хүрээгээ тодорхойлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн, технологийн тодорхой шинэчлэлтүүдийг хийсэн. Энэ төсөл үргэлжлэн хэрэгжээд хэрэгжихээр тавигдаж орж ирж байгаа. Хөрөнгө оруулалт дээр тавигдаж байгаа мэдээллийн технологийн чиглэлийн энэ хөрөнгө оруулалт бол шууд энэ цахимжилттай холбоотой ийм төсөв байгаа.

Мөн Монгол Улсын дээд шүүх Шүүхийн академитай хамт, хамтаараа Хангарди ордон руу нүүн шилжих зардал төсөв орсон байгаа. Ер нь их засварын ажил дуусаад 7 дугаар сард, 7, 8 дугаар сард Дээд шүүх, академи Хангарди ордон руу нүүнэ. Өнгөрсөн жил бид бүхэн одоо ашиглаж байгаа хуучин байр, тэгээд Хангарди ордныг жилийн хугацаанд засахтай холбоотой ашиглалтын зардлууд нь ноднингийн төсөв дээр суусан. Энэ жил бол ирэх жилийн төсөв дээр хуучин байраа Шүүхийн ерөнхий зөвлөлд шинэ дараагийн шатын шүүхэд шилжүүлээд өгөхөөр Хангарди, зөвхөн Хангарди ордны ашиглалтын зардал манай байгууллага дээр орж ирэх юм гэдэг утгаараа ашиглалтын зардал буурсан нь тийм шалтгаантай байгаа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу?

С.Заяадэлгэр: Бусад зардлуудыг бид бүхэн холбогдох салбарын яамдаас баталсан тарифын дагуу тооцож төсөвтөө тусгасан. Баярлалаа та бүхэнд. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Дууссан уу? Заяадэлгэр даргад баярлалаа. Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийн төсөвтэй холбоотой, холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт, дараа нь үг тусдаа байгаа. Алтангэрэл гишүүнээр, Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Сая өнгөрсөн намар ХЗБХ, манай Хүний эрхийн дэд хороо Дундговь аймагт очиж ажилласан юм. Тэгээд Дундговь аймгийн шүүхээр ороход жишээлбэл ингээд зориулалтын бус байрны асуудалтай байх жишээтэй гэдэг шиг яг ингээд аймаг болгонд энэ шүүхийн байрны асуудал ч гэдэг юм уу ийм асуудлууд тавигддаг. Тэгээд тухайн үед яах вэ ХЗБХ-ны зүгээс гишүүд явж байсан манай Нарантуяа-Нара гишүүн бид нар явж байсан. Тэгээд ер нь энэ чиглэлийн ийм судалгаа гаргах ёстой юм шиг байгаа юм. Тэгэхээр яг одоо улсын хэмжээнд 21 аймаг, Улаанбаатар хотын хэмжээнд яг энэ хатуу дэд бүтэц тийм ээ, хатуу дэд бүтэцтэй холбоотой төсөв нийтдээ хэчнээн хэмжээний ийм төсөв шаардлагатайгаас 26 онд жишээлбэл хэдэн хувь нь орж ирж байгаа юм бэ? Энэ нь ойрын жилийн төлөвлөгөөгөөр нь хэдэн он гэхэд энэ асуудлыг ер нь яг цогц шийдэл гаргах вэ? Нэг ийм багцаа хэрэгтэй байгаад байгаа.

Ноднин жил яах вэ 7 сарын 2-нд Их Хурал тангаргаа өргөөд, ингээд цаашаагаа яваад процесс явсан. Тэгэнгүүт нөгөө 2 хурлын завсар үрэгдсэн хаягдсан юмнууд их байсан байхгүй юу. Тэгээд таналтаар Ерөнхийлөгчийн хоригийн ар дээрээс хөрөнгө оруулалтын 20 хувь хасагдаад нэлээн юмнууд хасагдчихсан юм. Тэгэхээр яг энэ ШЕЗ-ийн төсвийг харж байна. Яг энэ нь ингээд зүгээр яах вэ ирэх жилийн төсөв ч гэсэн энэ нь хэчнээн хувь нь шүүхтэй холбоотой хатуу дэд бүтцийн асуудлыг шийдэж чадах уу гэсэн? Тэгэх юм уу, зөвхөн Дээд шүүх юм уу? Тэгвэл асуултаа жоохон өөрчлөөд агуулга нь яг адилхан. Дээд шүүхтэй холбоотой хатуу дэд бүтцийн асуудлаас хэдэн хувь нь орж ирж байгаа юм бэ, энэ 100 хувь шийдэгдсэн юм уу гээд асуучихъя. Саяын асуултыг тэгвэл тухайн хэсэг дээр нь асууя.

Ц.Сандаг-Очир: Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр дарга асуултад хариулъя. Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

С.Заяадэлгэр: Улсын дээд шүүх стандартын барилгатай болох асуудлыг 2 жил сүүлийн 2 жил төсөв, төлөвлөгөө нь Байнгын хороогоор орж ирээд батлагдаад, хэрэгжээд, одоо 90 хэдэн хувьтай Хангарди ордныг засварлан шүүхийн стандартаар засварлан тийшээ нүүж орох ажил 95 хувьтай байгаа. 7, 8 дугаар сард дуусгаад, Улсын комисс ажиллахаар бид нүүгээд орчихно гэсэн төлөвлөгөөтэй. Мөн сая таны асуусанчлан хууль хэрэгжүүлэхэд хатуу дэд бүтэцтэй холбоотой техник тоног, төхөөрөмж, шүүх хуралдааны шууд дамжуулалтын мэргэжлийн тоног, төхөөрөмжүүдээр бүрэн хангагдсан байгаа. Ирэх жилийн төсөв дээр 2 төрлийн хөрөнгө оруулалтын зардал орж ирж байгаа. Нэг нь Хангарди ордны лифт нь болохоор ашиглалтын шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарчихсан байгаа. Аюулгүй байдлын хувьдаа ч гэсэн. Тэгээд энийг энэ

лифтийг ирэх жилийн төсөв дээр засах, мөн багахан хэмжээний 1-ээс 4 дүгээр давхар нь дулааны алдагдалтай байдаг, тэгээд энийг ирэх жил бууруулъя гээд 200 гаруй сая төгрөгийн засварын зардал, 3 дугаарт мэдээллийн технологийн тэр шүүгчийн хэрэг судлалын хиймэл оюуны төслийг хэрэгжүүлэхэд нийтдээ 5,6 хэд билээ, тийм 5,6 тэрбум төгрөг тусаж орж ирж байгаа юм. Энэ асуудлууд шийдэгдчихвэл Улсын дээд шүүхийн хувьд байр, хатуу дэд бүтэц иж бүрнээрээ бүхэлдээ шийдвэрлэгдэнэ.

Ц.Сандаг-Очир: Болсон уу, болсон уу Эрдэнэболд гишүүн? Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдлыг хангах үүднээс ЗГ-ын 1 яам тэр дундаа магадгүй нэг шинжээч гэдэг юм уу, мэргэжилтний аманд багтаж биш, ХЗБХ-ндөө асуудлаа танилцаад, энэ ерөнхий зарчмын дагуу улсын төсөв дээр оруулж ирэх боломжийг нь энэ шүүх эрх мэдлийн байгууллагуудад өгөөд байгаа юм. Тэгэхдээ би яах вэ энэ зүйлээс нэг зүйлийг асууя. Өнөөдөр улсын эдийн засаг тийм амаргүй байна. Тэгэхээр ер нь зүгээр та хэдийн маань оруулж ирж байгаа энэ төсвийн саналыг харахаар тодорхой хэмжээнд төсөв жоохон нэмэгдэх талдаа байна. Энэ нэмэгдэж байгаа саналууд маань яг ямар үндэслэлээр, ямар хэрэгцээ шаардлага бий болоод нэмж байгаа билээ? Энийг ХЗБХ-ны гишүүд шийдвэр гаргахад итгэл үнэмшил төрөх үүднээс нэг тодорхой яг тайлбарлаач. Яг цалин хөлсний, урсгал зардал дээр ингэж байгаа, эсвэл яг сая Эрдэнэболд дарга тодорхой асуулаа даа. Ер нь зүгээр тодорхой тоног, төхөөрөмж гэдэг юм уу, эсвэл ЗГ-аас энэ Хангарди ордныг шилжүүлж өгсөн шүү дээ та бүгдэд. Энэнтэй холбоотой засвар үйлчилгээ янз бүрийн юм яах гээд байна уу? Яг тодорхой мэдээллүүдээ өгмөөр байна.

Сүүлдээ энийгээ хэдүүлээ ингээд яг ярилцах тэр механизм энэ тэрээ гоё ил тод, үндэслэлтэй байж байхгүй бол ХЗБХ ерөнхийд нь нэг орж танилцуулаад цохичихдог, Сангийн яам нь орж ирээд л дараа нь ингээд ярихад ч гэсэн эвгүй байдалд байгаа. Тэгэхээр би бол та нөхдөд хуулиар олгосон эрх хэмжээний асуудлыг бодитой үндэслэлтэй нэмэгдүүлж байгаа тэр зардлуудаа яг тайлбарлах ёстой гэж бодож байгаа юм. Тэгээд ер нь зүгээр шүүхийн захиргааны ажилтнууд жоохон сүүлийн үед хэт данхайх, олшрох тал байна. Энийг Шүүхийн ерөнхий зөвлөл дээр 30-хан хүнтэй орон тоотой байсан бол одоо ингээд 150, 60 хүнтэй байна. Улсын дээд шүүх ч гэсэн дэргэдээ судалгааны хүрээлэнтэй, Улсын дээд шүүхийн шүүгчид маань хүртэл 2, 3 туслахтай болчихсон байж байгаа. Тэгэхээр ер нь зүгээр цаашдаа нэг жоохон энэ хуулийн зохицуулалтын дагуу энэ ач холбогдол нь гарч байна уу? Ер нь заримдаа шүүх эрх мэдлийн байгууллага ч гэсэн ялгаагүй хэмнэлт ярьдаг баймаар байгаа шүү. Тэрнээс биш орон тоог л нэмэгдүүлж байх ёстой гэдэг хандлагаар яримааргүй байгаа юм, зардлыг дандаа нэмэгдүүлж байна гэдэг хандлагаар яримааргүй байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүдийг гишүүдэд ямар үндэслэлээр энэ зардлаа төсвөө энэ жилийн хувьд нэмж орж ирж байгаа юм бэ гэдэг зүйлийг маш тов тодорхой хариулж өгөөч гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Гишүүний асуултад Заяадэлгэр дарга ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Заяадэлгэр: Баярлалаа. Эрхэм гишүүний асуултад хариулъя. Энэ шүүхийн дээд, Улсын дээд шүүхийн төсвийн хувьд 2 гол төсөв урсгал төсвийн

ангилал өсөж байгаа юм. Цалингийн зардлын төсөв болохоор яагаад өсөж байгаа вэ гэхээр 1 дүгээрт өнгөрсөн онд нийт төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, шүүхийн салбарын албан хаагчдын цалин хөлс мөн нэмэгдсэнтэй холбоотой. Үүнээс гадна Хангарди ордон руу нүүн шилжих үед хуучин бол Хангарди ордны ашиглалтыг 60-аад хүний орон тоотой зохион байгуулж явдаг байсан юм байна лээ. Гэхдээ эд нар энийг бол бид 50 хувиар л оруулж ирж байгаа юм. Үйлчилгээний албан хаагчдаа тэгж өндөр нэмэгдүүлээгүй, бас хэмнэлтийн зарчмыг барьж байгаа.

Улсын дээд, юу нийт шүүгчдийн зэрэг дэвийн хувьд хуульд байгаа боловч нөгөө журам батлагдаагүй. Ийм учраас энийг тусгаагүй ерөөсөө. Тэгэхээр цалингийн хувьд одоогийн батлагдчихсан байгаа яг л тэр хэмжээгээрээ орон тоогоороо үржүүлээд л орж ирж байгаа. Манай хувьд онцлогтой. Шүүгчийн судлаач туслахын орон тоо ямагт хэмнэгдэж ирсэн. Тэгэхээр энэ ч гэсэн өөрөө бас энэ жил, ирэх жил хэмнэгдэх байх. Гэхдээ цалингийн зардал ерөөсөө ганц шилжүүлэн зарцуулж болдоггүй, зарцуулж болдоггүй хэмнэлт нь улсдаа ингээд буцаад хураагддаг тийм л ангиллын зардал учраас орон тоогоороо бодоод ороод ирсэн юм, ирсэн байгаа.

2 дахь зардал өсөж байгаа юу бол Хангарди ордон руу ордны ашиглалтын зардал өсөж байгаа. Хуучин манай барилгаас 2 илүү дахин том учраас ашиглалтын зардал бага хэмжээгээр өсөж байгаа. Шүүхийн академитай холбоотой хариултыг Эрдэнэчимэг захирал өгнө.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 2 дахь микрофон.

П.Эрдэнэчимэг: Шүүхийн академийн захирал Эрдэнэчимэг байна. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Шүүхийн академийн хувьд энэ жилийн өсөлттэй байгаа зардал нь цалин хөлсний зардал болон хичээл үйлдвэрлэлийн зардал 2 өссөн. Бусад зардлуудыг бууруулсан үзүүлэлттэйгээр тооцоолж орж ирсэн байгаа. Цалин өсөх болсон үндэслэл бол ЗГ-ын тогтоолоор Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн нийт ажилтнуудын цалин өссөн учраас яг тэр өссөн дүнгээрээ ирэх жилийн төсвийг тооцоолж үзэхэд цалингийн өсөлт харагдаж байгаа. Харин хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал 350 сая төгрөгөөр өсөж орж ирсэн. Энийг тооцоолж үзэж байгаа шалтгаан нь шүүхэд шинэ Шүүх байгуулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор тойргийн шүүхүүд дээр шүүгчид эрүү, иргэний хэргийг аль алийг нь шийддэг болсонтой холбоотойгоор бид сургалтыг нэмэгдүүлсэн хэлбэртэйгээр зохион байгуулах шаардлага үүсэж байгаа. Мөн 2026 оны 1 сарын 1-нээс Гэр бүлийн шүүх байгуулах болсонтой холбоотойгоор тухайн шүүх.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Сайн байцгаана уу. Энэ цалин хөлсний зардал чинь ингээд 8 тэрбум төгрөгөөр өсчихсөн байгаа юм, тэгээд ингээд 18 хүн шинээр ажилд авна. Тэгэхээр дунджаар жилийн 400 саяар, тэгээд сарын 30 сая төгрөгийн цалинтай хүн авах гээд байгаа юм уу 1 дүгээр асуулт? Одоо байгаа ажиллаж байгаа хүмүүсийн цалинг хэдэн хувиар өсгөхөөр 2026 онд тооцсон юм бэ? Тэгэхээр харин энэ юу байна л даа. Би бол жишээлбэл Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал эд нарыгаа хараад үзэхээр Улсын дээд шүүх маань өөрөө

дангаараа ингээд зардлаа ингээд данхайтал өсгөж болохгүй л гэж бодож байна. Тийм учраас 1 дүгээр асуулт түүн дээр авъя.

2 дугаарт энэ Сонгинохайрхан дүүрэгт 270 мянган м² газар авсан гэж, энэ яах гэж Улсын дээд шүүх яах гэж газар авч байгаа билээ нэг асуулт байгаад байна?

Дараагаар нь тэр хөрөнгийн зардал дээр тэрбум 111 сая төгрөгийг засварын ажлын ажиллах хүчний цалингийн зөрөө гээд мөнгө тусгачихсан байх юм. Энэ юу гэсэн үг вэ гэж ийм 3 асуулт байна. Төсөв дээр.

Ц.Сандаг-Очир: Заяадэлгэр дарга ажлын хэсгийн 3 дахь микрофон.

С.Заяадэлгэр: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. 18 хүнээр өссөн мөртөө цалингийн нийт сангийн өсөлт эрс өндөр байгаа тухай асууж байна гэж ойлголоо. Батлагдсан орон тоо өнгөрсөн жилээсээ сая түрүүний миний хэлсэн Хангарди ордон руу нүүж байгаатай холбоотойгоор л 18 хүний үйлчилгээний ажилтны тоогоор өссөн гэж ойлгож болно. Нийт цалингийн сан өсөж байгаа шалтгаан нь өнгөрсөн жилийн төрийн албан хаагчдын цалин нийтээрээ өссөн. Энэнтэй ижил индексээр шүүхийн салбарын албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор нийт цалингийн сангийн хэмжээ өсөж байгаа. Нийт урсгал зардалдаа манай цалингийн сан 78,4 хувийг эзэлж байгаа.

2 дугаарт засварын, тэр ажиллах хүчний нэмэлт зардал нь болохоор зэрэг тухайн жилүүдэд өнгөрсөн Хангарди ордны засвартай холбоотой юм. Хангарди ордныг засах үед ажиллах хүчний зардлыг Барилга, хот байгуулалтын яамнаас яаж тооцдог байсан бэ тэр тариф нь жил тутам шинэчлэн тогтоогдоод явдаг байсан учраас, явдаг. Тэгээд энэ мөнгө нь тэр хэмжээгээрээ тооцогдоод ингээд суугдаад явдаг. Бид бүхэн энэ Сангийн яамнаас энэ тодруулга чиглэлээ авч байгаад энэ жишгээр ирэх жил, өнгөрсөн жилийн хоёрын зөрөөгөө суулгаж өгсөн байгаа. Одоо хийчихсэн байгаа их засварын зөрөө гарч ирнэ гэсэн үг. Сонгинохайрхан дүүрэгт газар болохоор Шүүхийн академийн хүсэлтээр шүүгч нарын сургалтын бааз ирээдүйд байгуулах зорилгоор газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Өөр зардал төлөвлөлт одоогоор хийгдээгүй байгаа.

Ц.Сандаг-Очир: Соронзонболд гишүүн тодруулъя, 1 минут.

Л.Соронзонболд: Тэгэхээр Улсын дээд шүүх маань 2024 онд цалингаа ерөөсөө өсгөөгүй байсан гэсэн үг үү гэж асууя, 1 дүгээр асуулт? Хамгийн сүүлд хэзээ цалингаа нэмсэн бэ? Тэгэхээр чинь харин ийм жил болгон нэмдэг байж болохгүй шүү дээ. Ямар байгууллага хэзээ 40 хувиар нэмж байсан юм бэ?

Ц.Сандаг-Очир: Заяадэлгэр дарга.

С.Заяадэлгэр: Ер нь шүүгчийн цалин ШЕЗ-өөс шүүгчийн цалинг тогтоодог байгаа. Агуулга нь шүүгчийн шүүгчийн цалин нэлээд олон жил нэмэгдэхгүй тогтоогдсон хэмжээндээ явж ирсэн. Энийг өнгөрсөн жил Шүүхийн тухай хуульд өөрчлөлт орж шүүх эрх мэдлийн байгууллагуудын бие даасан хараат бус байдлыг хангахтай холбоотойгоор цалин нэмэгдүүлэх боломжийг ШЕЗ-д салбарыг нь оноосноор ШЕЗ-өөс шинэчлэн цалингийн сүлжээг баталсан байгаа. Тийм, ноднин жил нэмэгдсэн. Энэ жил нэмэхээр орж ирээгүй, нэмэгдэхгүй. Сан нь нэмэгдээд

байгаа нь өнгөрсөн жил болохоор нөгөө нэмэгдэл нь төлөвлөгдөөгүй оны эцэс рүү хагас жилээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Би Соронзонболд гишүүний асуултыг гүйцээгээд асуучихна. Шүүхийн шүүгчдийн цалинг Улсын Их Хурлын тогтоолоор жишиг байдлаар тогтоож явж ирсэн юм. Ер нь бусад төрийн албан хаагчдын цалин зэрэглэлд өөрчлөлт ороод нэмээд яваад байдаг, шүүгчийн цалин Улсын Их Хурлын тогтоолоор батлагдчихсан байсан учраас энэ хөндөгдөлгүй 10 гаруй жил явчихсан юм. Тэгээд сүүлдээ мөрдөгчдийн цалингаас бараг шүүгчийнх нь цалин 50 хувь бага эд нар болчихсон ийм болсон түүхтэй. Тэгээд Улсын Их Хурал дээр шүүгчдийн цалин ярихаар улс төржөөд байдаг, энэ нэг хэдэн авлигачдад тэгээд ер нь бараг цалин өгөх ч яадаг юм гээд бүр тэр лүү нь саваад байдаг. Тэгээд шүүх эрх мэдлийнхээ энэ хараат бус байдлыг хангах зорилгоор өнгөрсөн онд Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, Шүүхийн ерөнхий зөвлөл батлагдсан орон тоо, цалингийнхаа санд багтаагаад шүүгчдийнхээ цалинг өөрөө тогтоож байх бүрэн эрхийг Улсын Их Хурлаас анх удаа олгосон юм. Энэ маш том боломж байгаа.

Энэ хүрээ рамдаа би өнгөрсөн оны 12 сард төсөв, 11 сард төсөв батлах үеэр ШЕЗ-өөс тодорхой хариулт асуугаад авч чадаагүй. 5 сард энэ өөрчлөлт орсноос хойш ШЕЗ шүүгчид, захиргааны ажилтнуудын цалинг 2, 3 удаа нэмсэн гэдэг ийм мэдээлэл байгаад байсан. Өөрөөр хэлбэл батлагдсан орон тоогоо маш том тавиулж байгаад, овоо мөнгө тавиулж байгаад цалингаа нэмээд байдаг. Хэрвээ тэр орон тоо нь дүүрвэл тэр шүүгчдийн чинь цалин буурна гэсэн үг байхгүй юу. Тийм учраас энийгээ ер нь яаж интервал тогтоож явж байгаа юм бэ гэдэг асуултыг би асуугаад байсан юм. Тэгэхээр одоо би яг тодорхой асуух гэж байна. Ер нь Улсын дээд шүүхийн судалгааны хүрээлэн, Улсын дээд шүүхийн шүүгчдийн судлаач туслах гэдэг энэ орон тоог жишээлбэл Алтанхуяг гишүүн бид чинь Шүүхийн хууль батлахдаа Сандаг-Очир гишүүн байсан, бид хэд ярьж байгаад энэний уг нь аль нэгийг нь өгөх гэж байсан юм. Дээд шүүхийн дэргэд эсвэл судлаач туслахтай бай, эсвэл судалгааны хүрээлэнтэй бай гэж. Тэгээд хэлэлцүүлгийн явцад явж, явж байснаа эцсийн хэлэлцүүлэг дээр энэ санал гараад судлаач туслахтай, судлаач хүрээлэнтэй болчихсон юм ингээд давхар. Тэгээд энэ орон тоо цалин нь нэмэгдээд байгаа дүр зураг эндээс үүдэлтэй.

Тийм учраас одоо яг Улсын дээд шүүх хэчнээн судлаач орон тоотой яг ажиллаж байна вэ, одоо яг ажиллаж байгаа орон тоог нь? Би энийг нэмэх шаардлагагүй гэж хэлэх гэж байна. Яагаад гэхээр бүхэл бүтэн хүрээлэнтэй болчихсон байхгүй юу, зөвхөн судалгааны хүрээлэнтэй, зөвхөн Дээд шүүхийн 24 шүүгчид үйлчилдэг шүү бүр. Одоо хэчнээн судалгааны хүрээлэн, хэчнээн судлаачтай байна вэ яг орон тоо? Би энийг цаашаа.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 дахь микрофон. Яасан бэ? Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

С.Заяадэлгэр: Шүүгчийн цалинг хэдэн удаа нэмсэн бэ гэж ШЕЗ-өөс 24 оны 274 дүгээр тогтоолоор нэг удаа нэмэгдүүлсэн. Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын дээд шүүхийн шүүгч 3 хүртэл судлаач туслахтай байна гээд хуульд заачихсан байгаа Шүүхийн хуульд. Шүүхийн академи болохоор нийт шүүгчдэд судалгааны мэдээллийн, сургалтын энэ чиг үүргээр үйлчилгээ үзүүлж байна,

хамаарч байгаа. Тэгээд одоо бол бид дотооддоо энэ зохион байгуулалтыг хийгээд, Дээд шүүхийн шүүгч нь судлаач туслахаараа судалгаагаа хийлгээд, Шүүхийн академид нийтлэг бусад анхан, давахын энэ тэр бүх шүүгчийн. Шүүхийн академи маань үе шаттайгаар чадавхжиж байгаа. Шууд Дээд шүүхийн судалгаануудыг тэр бүр хийхэд бэлэн биш. Магадгүй үе шаттай энэ асуудлыг авч үзэх нь зөв байх. Хуульд өөрчлөлт орж байж шийдвэрлэхгүй бол өнөөдөр төсөв хасах замаар шийдвэрлэвэл одоо энд ажиллаж байгаа хүмүүсийн Шүүхийн дээд шүүхийн бүрэн эрх хөндөгдөхөөс гадна, шүүгч нарын бүрэн эрх хөндөгдөхөөс гадна, энд ажиллаж байгаа судлаач туслах нарын эрх зүйн байдал хөндөгдөх үр дагавартай учраас эрх зүйн орчноос нь эхэлж дахин авч үзэх нь зүйтэй байж магадгүй.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн тодруулъя.

Б.Энхбаяр: Заяадэлгэр даргаа ийм байхгүй юу. Өнгөрсөн парламент ер нь шүүхэд хайр сэтгэлээ харамгүй зарцуулсан юм. Би бараг шүүхийн хэвлэлийн төлөөлөгч шиг ажилласан хүн. Нээрээ шүү, хайр бол Улсын Их Хурлаас ихдээгүй юм. Би сая хэлээд байна шүү дээ. Нэг шүүгчид 3 судлаачийн орон тоо гаргаж өгсөн. Тэгэхдээ бид 23 онд нэг судлаачийн орон тоог нэг шүүгчид төсвөөр нь дамжуулж шийдсэн. Би тодорхой асуугаад байна шүү дээ. Өнгөрсөн онд Улсын дээд шүүхийн 24 шүүгчид хэдэн орон тоо нэмсэн бэ, гүйцэтгэл нь ямар байгаа юм бэ? Хэдэн Дээд шүүхийн судалгааны хүрээлэн одоо яг хэдэн орон тоотой судлаачтай ажиллаж байна вэ гэж асуугаад байна шүү дээ. Тэгэхээр тэр орон тоог хасвал болохгүй гэдэг юм яриад байна. Хасаж болно. Яагаад гэхээр би нэмсэн шалтгааныг нь хэлчихлээ шүү дээ аль нэгийг нь хийж өгнө гэж байгаад хоёуланг нь шийдчихсэн байхгүй юу даа. Тэгэхээр бид Шүүхийн хуульдаа.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон, Заяадэлгэр дарга.

С.Заяадэлгэр: Нийт Улсын Дээд шүүх болон Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академид 108 судлаач нийтдээ бүтэц орон тоо хуулийн хүрээнд тогтоогдож байгаа. Эндээс одоогийн байдлаар нийтдээ 48 судлаач ажиллаж байна. Улсын Дээд шүүхэд 3 хүртэл гэвэл 75 судлаач туслах ажиллах хуулийн боломж байгаа боловч одоогоор 24 буюу нэг шүүгчид нэг судлаач туслах л ажиллаж байгаа. Энэ судлаач туслахыг жилд 3 хүртэл гэж нэг дор шийдвэрлэхгүй жилд нэгээр, эхний жил нэг судлаач, дараагийн жил нь дахиад нэг судлаачаа сургаж бэлтгэх юм уу ийм үе шаттай шийдвэрлэж явж байгаа. Тэгэхээр ирэх жил бас судлаач туслахуудыг нэмэгдүүлэх, Академи мөн адил тал орон тоогоор ажиллаж байгаа. Ирэх жил бүтэн чадавхжих байх. Ийм зорилт тавьж байгаа.

Ц.Сандаг-Очир: Норовын Алтанхуяг гишүүн асуултаа асууя. Ганбат гишүүнийг нэмчхээрэй асуултад.

Н.Алтанхуяг: Энэ Шүүхийн хууль хийхэд нэлээн ярьсан юм. Энхбаяр гишүүний гарсан дүр зураг ер нь би энэ төрийн байгууллагуудыг харахад шүүх жаахан онцлогтой. Тэгэхдээ ерөнхийдөө байшин томордог, орон тоо нь томордог, тэгээд нөгөө шударга ёс сахиулах юм чинь аль зэрэг энийг дагаж өсөж байгаа доо? Би эргэлзэж байгаа. Тэгэхээр надад ямар асуулт байгаа вэ, асуулт биш юм даа бараг, би энэ танилцуулга хараад бараг ойлгочихлоо. Энэ Тэмүүжин сайдын үед эхэлсэн 2 байшин суурин л байх ёстой одоо босож байна уу, үгүй юу мэдэхгүй. Та нарын энэ төсвийг харахаар дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр нь Хан-Уулынх болохоор 91 тэрбумаас 26 онд 58-ыг тавьсан байх юм. Ингээд энэ шинээр эхлэх

шүүхийн байшингуудаа зогсоогоод энэ дээрээ нэмчихвэл энэ жил энэнийг бараг барьчихаар байх юм л даа. Бид авто замыг яаж хурдан бариад байсан юм гэхлээр олон компани зэрэг оруулаад л барьчихдаг байхгүй юу. Одоо ингээд нэг компани авахаараа ингээд л үхрийн баас шиг ингээд гоожуулаад л, тэгээд жилээс жилд. Тэгээд л тэгээд энд тэнд ингээд суурь тавиад, тэр суурь нь жилээс жилд инфляцаас болж өсөөд, ингээд явдаг юм.

Дээр нь би нөгөө хүнээ бодоод байна, үйлчлүүлэх гэж байгаа иргэдээ бодоод байна. Шүүхийн барилга байшин гэдэг үйлчилгээний байшин байх ёстой юм гэдэг концепцоор Тэмүүжин сайдын үед хийсэн юм. Энийг гүйцээмээр байна. 2 дахь нь бусдыг нь хасчихмаар байна. Шинээр орж ирж байгаа тэр нэг ийм хоёрын хооронд юм тавиад байна. Тэгээд энэ Зүүн бүсийн шүүхийн цогцолбор барилга, Хан-Уул 2-ыг үлдээгээд л хиймээр байна. Би их тодорхой санал ярих гээд байна. Би ер нь энэ 26 оны төсөв дээр нэг иймэрхүү юмаа жаахан хэлэхгүй бол яг л хуучин нэг байшингийн суурь тавиад, тавиад л жоохон, жоохон нэмээд, нэмээд явдаг энэ их үр бүтээл муутай л даа. Тэгээд жижигхэн матаас хэлэхэд энэ Дархан, Орхон гээд нэг байшин тэнд том шүүхийн барилга бариад л, манай Сангийн сайд л давхиад байх юм. Дарга нарын байгаа сонгогдсон тойргууд биш, иргэд олон байгаа газрууд дээрээ л энэ юмаа үйлчилгээнийхээ юмыг л босгох иймэрхүү бодлого хийж болохгүй юм уу? Та нар энийг юу гэж бодоод байгаа юм бэ? Би их тодорхой санал хэлээд байна шүү дээ. Энэ хоёрын хооронд шүүхийн сууриудаа хасчхаад, энэ 2-ыг босгочихмоор байна болох уу, болохгүй юу, хүсэл байна уу, байхгүй юу? Та ч бас хэлэхгүй л байх л даа энэ тэр дарга нарын л асуудал. Тэгэхдээ нэг хэлчхээч хариулаадхаач.

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүний асуултад Заяадэлгэр дарга.

С.Заяадэлгэр: Баярлалаа. Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Шүүхийн анхан, давах, давж заалдах шатны шүүхийн барилгын асуудал ШЕЗ-д хамаарч байгаа манай төсөвт тусгагдаж орж ирэхгүй, ирээгүй. Ер нь таны асуусан 2 барилга ашиглалтад ороогүй байгаа. Ашиглалтад орсноор нийслэлийн тойргийн 2 шүүх тэнд байрлан үйл аж ажиллагаа явуулах ийм зорилтыг тавиад явж байгаа юм.

Өмнөх энэ Энхбаяр гишүүний асуултад уучлаарай дутуу хариулсан байна нэмж тодруулъя. Улсын Дээд шүүхийн судлаач туслах болохоор зэрэг практик буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, нөгөө төсөөтэй хэргийнхээ судалгааг хийдэг. Дээд шүүхээр 21 хоногийн дотор хэргийг шийдвэрлэх ийм богино хугацаатай учраас судлаач туслах энэ дээрээ ажиллаад таардаг. Академийн хувьд олон улсын онол практикийн харьцуулсан судалгааг хийдэг. Тэгээд анхан давахынхаа шүүхүүдийн хэрэгцээтэй судалгаануудыг хийдэг. Ер нь давхцал байхгүй байгаа.

Ц.Сандаг-Очир: Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Монгол Улсын эдийн засаг их хүнд байгаа. Тэгээд өнгөрсөн жил шүүгч нарын цалинг яг Энхбаяр гишүүн манлайлаад, нэмэх талаар манай ХЗБХ сайн ажилласан, цалинг нэмсэн. Гэтэл энэ жил дахиад дунджаар Дээд шүүхийн шүүгч нарын цалинг болон ажилчдын цалинг 46 хувиар нэмэх тухай асуудлыг оруулаад ирж байна. Ер нь миний өргөн барьсан энэ тэтгэврийг индексжүүлэх тухай хуулиар 550 мянган төгрөгийн тэтгэвэртэй ахмадуудын

тэтгэврийг нөгөө энэ жилийн инфляц 10 хувиар байлаа гэхэд 10 хувиар нэмэх юм л даа. Тэгээд ирэх жилийн төрийн албан хаагчдын цалинг яг тэр хувиар л нэмэх байх. Гэтэл энэ танайх ингээд хавар нь батлуулдаг энүүгээрээ ингээд эдийн засгийн төлөв байдлыг харж мэдэхгүйгээр тийм ээ, жилийн эцсийн нөхцөл байдал юуг мэдэхгүйгээр бид ингээд нэмээд тавьчихдаг. Тэгээд өнөөдөр яагаад ингээд Цогтбаатар дарга байхгүй байна гэхээр яг төсөв хэлэлцэх болохоор бөөн хэл ам болдог байхгүй юу даа. Эд нарын цалинг ингээд замбараагүй нэмчихсэн, бусад хүмүүсийгээ яалаа энэ тэр гээд л. Тэгээд тэгэнгүүт Цогтбаатар дарга нөгөө нэг олон жилийн дунджаар юмаа мэддэг болохоор хавар би хурал даргалаагүй гээд Сандаг-Очир чамд үлдээхээд явчхаж байгаа байхгүй юу даа. Тэр нь бол, ер нь иймэрхүү, иймэрхүү юм болно. Би зүгээр яг, би энд олон жил энд ХЗБХ-нд суусны хувьд хэлж байна.

Тийм учраас жишээ нь 2, би та нарт Энхбаяр даргаа би ганц юм хэлчихье. Энэ ингээд хоёр аравны, 25 шүүгчийн цалинг 2,9 тэрбум байна. Энэ чинь энэ чинь цалин бол нэг ойролцоогоор гар дээрээ 5, 4,5-аас 5 орчим сая төгрөг авдаг юм байна шүүгчид. Гэтэл энэ нь 7,5 сая болоод нэмэгдэх юм байна л даа 46 хувиар. Гэтэл нөгөө нэг дөнгөж 600-хан мянган төгрөгийн тэтгэвэртэй байгаа хүмүүс 10 хувиар нэмж байдаг. Гэтэл та нар ингээд 2, 3 сая төгрөгөөр нэмэхлээр чинь энэ чинь адилхан л амьд хүн тэгээд яаж амьдрах юм бэ? Ийм байж болохгүй. Энэ чинь яг нөгөө нэг намар төсөв хэлэлцэх үед хүнд нөхцөл байдал бий болгоно.

Тийм учраас би энд янз янзын хэл ам гарахаас өмнө горимын санал гаргаж байна. Энэ Дээд шүүхийн болон Шүүхийн сахилгын хороо, Хүний эрхийн Үндэсний хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ дандаа бүгдээрээ 40-өөд хувиар цалингаа нэмэхээр ороод, оруулаад ирсэн. Энэ саналуудыг энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлаас хойшлуулах. Ирэх долоо хоногт энийгээ энэ нийгэм, эдийн засагтайгаа холбож, зөв болгож оруулж ирэх, дээрээс нь Засгийн газар 14 мянган хүнийг төрийн албан хаагчийг чөлөөлнө гэж зорилт тавиад явж байгаа. Гэтэл бүх байгууллагууд бүгдээрээ ажилтан нэмнэ гэж орж ирж байна. Тийм учраас яг тодорхой хэмжээгээр яг тэр Засгийн газрын.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Пүрэвдорж гишүүн 1 минут.

Б.Пүрэвдорж: Засгийн газар гүйцэтгэх засаглалаас хэдэн хувиар төрийн албан хаагчийг цомхотгож байна яг тэр хувиар өнөөдрийн байгаа орон тооноосоо цомхотгож орж ирэх, энэ эдийн засгийн нөхцөл байдалд тааруулах ийм шинэ саналыг ирэх долоо хоногийн дотор оруулж ир гэдэг ийм горимын санал гаргаж, энэ хэлэлцэх асуудлын асуудлаас энэ 4-ийг хойшлуулах, ийм долоо хоногоор хойшлуулах ийм горимын санал гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү?

Ц.Сандаг-Очир: Цогтбаатар дарга гадаадаас ирсэн айлчлалын хүмүүстэй байгаа учраас чөлөө авсан гэдгийг хэлье. Горимын санал гаргачихлаа. Ганбат гишүүн асуулт асуухаар байна. Яах вэ? Таныхаар хураалгана л даа. Ганбат гишүүний асуултын дараа хураалгачхаж болох уу, тэгэх үү? Ганцхан хүн байгаа юм чинь. Ганбат гишүүний асуултыг асуулгачихъя тэгэх үү? Тэгээд Пүрэвдорж гишүүний горимын саналыг хураалгачихъя.

Д.Ганбат: Төсвийн тодотголоор Улсын дээд шүүхийн энэ төсвийн төсөл орж ирж байна л даа. Энд нэг иймэрхүү юм байна. Энэ асуулт, хариулт энэ юмыг нь хараад байхад жил болгон л инфляц явж байгаа шүү дээ. Тэгээд тэрэнтэй

уялдуулаад шүүгч нарын цалин нэмэгдэж байх ёстой л доо. Шүүгч нарын цалин байтугай энэ улс орны ажил төрөл хийж байгаа бүх хүмүүсийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, цалин нэмэгдэж байх ёстой. Тэр дотроо онцгойлон шүүгчид чинь эрхээ хасуулсан хүмүүс байхгүй юу. Энд тэнд архи дарс уугаад, орой үдэш янз бүрийн нэмэлт ажил хийгээд байх тэр эрх нь бүгдийг нь хасчихсан ийм зүйл шүү дээ. Тэгээд энэ юмыг олигтойхон зөв тайлбарлаж өгөх хэрэгтэй. Улсын дээд шүүх бол. Тийм юм алга байна.

Олонх нэг нам эрх бариад ингээд явж байсны үр дүнд энэ Улсын дээд шүүх дээр Шүүхийн ерөнхий зөвлөл гээд байсаар байтал энэ Академи гээд янз бүрийн юмнуудыг наачхаад байгаа байхгүй юу. Энэ болохгүй л дээ. Энэний үр дүн нь одоо гарч ирж байна. Энэ чинь аж ахуйн ажлыг тэр социализмын үед Улсын дээд шүүх дээр авчирч ирээд хийгээд байдаг байсан юмыг салгая гээд ингэж л хийсэн ажлыг 2, 3 жилийн өмнө билүү, Улсын дээд шүүхийнхэн эрх баригчтай наймаалцаж байгаад, тэгээд өөр дээрээ татаад авчихсан. Тэгээд тэр нь яах вэ бусад шатны шүүгч нарынхаа тэр томилгоо, сургалт ийм юмыг ямар нэгэн байдлаар хараатаар шийддэг ийм болчхоод байгаа шүү дээ. Тэгээд наадах чинь гадна, дотнын судалгаа энэ юмаараа яаж гарч байгаа юм бэ, үр дүн нь ямар байна вэ? Улсын дээд шүүхийн шүүгч нараас асууж болдоггүй, тэгээд Улсын дээд шүүхийг төлөөлөөд ирж байгаа хүмүүсээс асууя. Шүүх чинь засаглал байх ёстой, тэр хараат бусаар Үндсэн хуульд заасны дагуу засаглаж чадаж байгаа юу?

Бид сонсгол хийгээд Хөгжлийн банк, өчнөөн л юм байгаа шүү дээ нүүрсний хэрэг. Тэгээд энэ юман дээр олигтой тэгээд яг тэр иргэдийн хүсэн хүлээсэн шиг иргэдэд өгдөг шиг ял шийтгэл бол өгдөггүй шүү дээ. Тэгээд бусад бүх шүүгчид адилхан. Тэр бүхнийхээ хараат бус ажиллах боломж, бололцоо энэ юмнуудыг хангаж ажиллах ёстой. ШЕЗ-өө шаардаж ажиллах ёстой, Шүүхийн сахилгын хороогоо шаардаж ажиллах ёстой бүх шүүгчид. Энэ юмаа хийж байна уу, хийхгүй байна уу? Тэгээд нөгөө юу билээ, нөгөө амьтан, амьтан дотроос бас нэг амьтан бүр илүү эрхтэй гэдэг шиг энэ олон шүүгчид дотроосоо Улсын Дээд шүүхийн шүүгч бүр илүү эрхтэй болчхоод байгаа юм уу, ямар байгаа юм бэ? Энэ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Заяадэлгэр дарга.

С.Заяадэлгэр: Баярлалаа. Ганбат гишүүний асуултад Шүүхийн академийн захирал Эрдэнэчимэг хариулна. Миний хувьд сая Пүрэвдорж гишүүний хөндсөн асуудал дээр тодруулга өгөхийг хүсэж байна. 2024 онд нэмэгдсэн цалин л таны 46 хувиар цалингийн санг ирэх жил нэмэх гээд байна гэдэг нь өнгөрсөн хойно нэмэгдсэн байгаа дүнгээрээ тусгаж орж ирсэн нь байгаад байгаа. Өнгөрсөн жил болохоор яаж энэ цалингийн нэмэгдлээ олгож байсан гэхээр нийт системийн хэмжээнд нэлээд их хэмнэлт орон тооны хэмнэлт шүүгчийн орон тоо бүрдэхгүй ч юм уу, сонгон шалгаруулалтууд явж байдаг энэ байдлаас болоод оны эцэс рүү шийдвэр гарсан. Энэ хэмнэлтээрээ бид цалингийнхаа нэмэгдлийг энэ жилдээ өгөөд явж байгаа. Энэ 24 оноос 25 он дамжин нэмэгдсэн энэ 46 хувь орчим хувийн нэмэгдлийг л манай шүүх байгууллагууд нийтээрээ төсөв дээрээ тусаж орж ирж байгаа юм.

Өмнөх онуудад нөгөө урьдчилан мэдээж авах боломжгүй учраас өнгөрсөн жилийн нэмэгдэл өнгөрсөн жилийн төсөв дээр байхгүй байсан гэсэн үг. Хэмнэлтээрээ зохицуулсан байгаа юм. Тэгэхээр одоо энд ноднин нэмэгдсэн

нэмэгдлийг байхгүй болговол нэг удаагийн нэмэгдсэн энэ үйл ажиллагаа маань буцаад хасагдах юм руу орох болох юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Одоо таны горимын саналаар санал хураалгалаа шүү дээ. Та тодруулж болно, Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тодруулъя. Нэг хэсэг наад сургалт судалгаа, томилолт энээ тэрээ юм чинь ШЕЗ дээр байсан миний санаж байгаагаар. Тэгээд хуульд өөрчлөлт оруулаад Дээд шүүх татаж аваад ингэчихсэн. Тэгээд та нар өнөөдөр ингээд аж ахуйн ажил яриад сууж байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь ч шүүхийн нэр хүндэд, Дээд шүүхийн шүүгч нарын нэр хүндэд нөлөөлнө. Энэ зөв байна уу, үгүй юу? Тэгээд судалгаа хийдэг юм байна тийм ээ академи чинь? Та нарын тэр судалгаа энэ тэр, зарчим чинь яг яаж гараад байгаа юм бэ, юу гэж үздэг юм бэ? Тэрийг нэг тодруулаад хэлээд өгөөч надад.

Ц.Сандаг-Очир: Заяадэлгэр дарга, ажлын хэсгийн 2 дахь микрофон Эрдэнэчимэг дарга Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал.

Д.Эрдэнэчимэг: Би Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирал Эрдэнэчимэг байна. Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн анх ШЕЗ-ийн дэргэд ажиллаж байгаад 21 оны Шүүхийн тухай хуулиар Дээд шүүхийн дэргэд бие даасан бүтэцтэйгээр ажиллахаар зохион байгуулагдсан. Үүний шалтгаан юу вэ гэхээр Монгол Улсад үйл ажиллагаа шүүн таслах ажиллагаа эрхэлж байгаа нийт шүүгчдийн сургалт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох болон хуулийн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой судалгааг шүүхийн Дээд шүүхийн дэргэд авчрах нь олон улсын зарчим буюу Бангалорын зарчимтай нийцэх нь гэж үзсэн учраас шилжүүлэн авчирсан байгаа.

Мөн түрүүн Энхбаяр гишүүний асууж байсан асуулт дээр нэмэлтээр хариулахад Шүүхийн академи нийтдээ 35 орон тоотойгоор ажиллаж байгаа. Энэ 35 орон тооны 15 судлаач буюу 4 секторт харьяалагдаж ажиллаж байгаа. Тэгээд Шүүхийн академийн хийж байгаа судлаач нарын хийж байгаа судалгаа Дээд шүүхийн судлаач туслахуудын хийж байгаа судалгаатай.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут гүйцээгээд хариулчих.

Д.Эрдэнэчимэг: Судалгаанууд нь давхардахгүй байгаа. Яагаад гэхээр Дээд шүүх дээр нөгөө хуулийн нэгдмэл байдлыг хангах болсонтой холбоотойгоор төсөөтэй хэргийн судалгааг судлаач туслахууд хийдэг. Манай шүүхийн академийн судлаачид олон улсын харьцуулсан судалгаа, хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой судалгаа болон бусад нэгдмэл байдлыг хангахтай холбоотой, эсвэл шүүгч Дээд шүүхээс гарч байгаа хуулийн тайлбарын судалгаануудыг хийдэг байгаа. Тэгэхээр судалгааны давхцал ерөөсөө байдаггүй. Манайх нийтдээ 28 судлаачтай байхаар төлөвлөсөн боловч одоогийн байдлаар 15 судлаачтай ажиллаж байгаа. Тэгээд дан ганц Дээд шүүхийн судлаач шүүгч нараас захиалга авдаггүй, анхан, давах шатын шүүгч нарын судалгааг авдаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой судалгаануудын захиалга бол нэлээд сүүлийн үед их орж ирж байгаа. Энэ нь бид практикаараа төсөөтэй шийдвэрлэсэн байдлын судалгааг анхан, давах шатын шүүгч нарт хийж өгч байгаа. Тийм учраас

судлаач нарын давхцал байхгүй гэж харж байгаа. Ерөнхий зөвлөл бол шүүгч нарыг сонгон томилдог байгууллага учраас сургалтаа зохион байгуулж байгаа байгууллага нь энэ захиргааны байгууллагаасаа тусдаа байх нь зүйтэй байна.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж дууслаа. Пүрэвдорж гишүүн горимын санал гаргасан. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 26 оны төсвийн төслийг долоо хоногоор хойшлуулъя, өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулъя гэдэг горимын санал гаргаж байна. Микрофон дээр горимын саналаа нэг тайлбарлаадах, Пүрэвдорж гишүүний микрофон.

Б.Пүрэвдорж: Нийт байгууллагууд чинь бүгдээрээ ингээд төсвөө нэмэгдүүлээд ороод ирчихсэн байна. Ихэнх нь цалингаа 40 гаруй хувиар нэмэгдүүлэхээр, зарим нэг байгууллага нь конторын барилга барина гээд ороод ирчихсэн байна. Тэгэхээр энэ чинь улс орны төсөв энэ хүнд байж байхад ийм өндөр хувиар нэмж болохгүй. Дээрээс нь ЗГ 14 мянган хүнээр төрийн албан хаагчаа хална гэж байна. Гэтэл бүх орон тоогоо нэмэгдүүлнэ гээд ороод ирж байна. Тэгээд энийгээ бүгдийг нь яг хэдэн хувиар гүйцэтгэх байгууллагаас хасаж байна, яг тэдэн хувиар нь энэ байгууллагуудаасаа төрийн албан хаагчийг цомхотгох энэ зүйл, бүх зүйлээ оруулж ирэх ёстой. Бид ЗГ нэг талдаа нэг юм яриад байхад энэ Их Хурлын харьяа байгууллагууд нь тэрэнтэйгээ нэгдэхгүйгээр, төрийн албан хаагчаа цомхотгохгүйгээр ингээд сууж байж болохгүй 1 дүгээрт.

2 дугаарт эдийн засаг хүнд байж байхад конторын барилга барьж болохгүй. Ийм, ийм зүйлүүд байна.

Дээрээс нь би сая тэр шүүгчийн цалинг таны хажуу талын хүнээс нийт тусдаа өөрийнх нь компьютероос 2,9 тэрбум болж нэмэгдсэн гэхээр л би тэр тоон дээр 25 шүүгчийн цалин 24 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийг нь хасаад ингээд гаргаад ирэхэд 7,4 сая төгрөг болж байна л гэж би хэлсэн. Гэтэл яагаад ингээд намайг хажуу талынхаа хүнтэй гүтгээд байгаа юм бэ? Би ерөөсөө энэ дандаа баримт дээр үг хэлдэггүй шүү гэдгийг хэлье. Тэгээд миний гаргасан саналын дагуу энэ ирэх жил бол төрийн албан хаагчдын цалинг инфляцын дагуу л нэмэх байх. Тийм учраас ядаж инфляцдаа баригдуулаад тоогоо нэмээд хүрээд ир. Тэгвэл бид энэ оны эцсээр төсөв хэлэлцэхэд энийг чинь хамгаалаад гаргаж өгч чадна. Гэтэл энэ замбараагүй нэмээд ороод ирэхээр чинь бусад бүх байгууллагууд бүгдээрээ барьцаад ороод ирнэ. Тэрнээсээ болоод бүх юм унана. Тийм учраас би энэ шүүгч нарын цалинг угаасаа нэмэхийг үргэлж л дэмжиж байсан. Тийм учраас энэ бодит байдал дээр та нар ингээд юмаа оруулаад ирээч л гэдэг ийм хүсэлтийг хэлж, энэ горимын саналыг гаргаж байгаа юм гэдгээ хэлье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Горимын саналыг дэмжиж үг байхгүй. Горимын санал гарсан учраас гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 26 оны төсвийн төслийг өнөөдрийн 25-ны ХЗБХ-ны хуралдаанаар хэлэлцэхээс хойшлуулж, долоо хоногоор хойшлуулах горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Тэгвэл санал хураалтыг цуцалъя, санал хураалтыг цуцалъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүд санал хураалтад бэлдсэн бол горимын саналыг уншиж хэлсэн. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор

санал хураалт. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжиж, 73,3 хувийн саналаар өнөөдрийн ХЗБХ-ноос нэр бүхий 4 байгууллагын 26 оны төсвийн төслийг долоо хоногоор хойшлуулъя гэж үзэж байна.

Та бүхэн ирэх жил өнөөдөр ингээд улсын төсөв тодотгол хийх гээд өргөн баригдаж байна. Төсөв, улсын төсөв 3,3 их наядоор тасраад явж байна. Үлдэж байгаа хагас жилд оны эцэст төсөв санхүү ямар байхыг бид мэдэхгүй байна. Нүүрсний үнэ уначихсан байна, ганц орлого ордог салбар маань. Тийм учраас энэ эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж, төсвөө дахиж нягталж харж, Сангийн яамтай ахиж ярьж хөөрч, ингэхгүй бол өнөөдөр гишүүд та бүхний төсвийн төсөлтэй төдийлөн танилцаж амжаагүй байна гээд олон шалтгаанууд байгаа учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаас хойшлуулж байгаа шүү гэдгийг ойлгоорой. Баярлалаа.

13.04 цаг

2 дахь хэлэлцэх асуудалдаа орёе. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг. 2 дахь хэлэлцэх асуудалтай холбогдуулж Номинчимэг гишүүн горимын санал гаргая гэж байна. Номинчимэг гишүүний микрофон.

О.Номинчимэг: Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг дээр гишүүдэд тараагдсан санал дээр нэг тэмдэглэгээний алдаа гарсан. Энийг ажлын хэсгийн Тамгын газрынхан маань тэмдэглэгээг нь засаж орж ирэхээр ажиллаж байгаа юм байна. Тэгэхээр энийг хийгээд тараах хүртэл нэг жоохон хугацаа байгаа учраас энэ асуудлыг Эрүүгийн процессын хуулийн дараа хэлэлцүүлэхээр дарааллыг нь өөрчилж өгөөч. Цаг хэмнэх үүднээс бид Тамгын газар принтлээд авчрах хүртэл дарааллыг нь өөрчилж өгөөч гэсэн горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Номинчимэг гишүүн, өнөөдөр чинь 3 асуудал хэлэлцэнэ. Тэгээд 2-хон асуудал үлдсэн байгаа. Тэгээд дарааллыг нь л өөрчлөх юм байна тийм үү? Номинчимэг гишүүний гаргасан горимын саналаар 2 дахь асуудлыг 3 дахь асуудал болгож өөрчилж өгөөч гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүд санал хураалтдаа бэлдсэн үү? Бэлдсэн үү санал хураалт? Номинчимэг гишүүний гаргасан горимын саналаар хэлэлцэх асуудлын дарааллын өөрчилье гэсэн томьёоллоор санал хураалт. 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62,5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн байна. Сайнзориг гишүүнийг дэмжсэнд протоколд оруулаарай.

Хоёр.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Тэгвэл 2 дахь асуудал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газар 24 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг асуудалд оръё. Санал уу? 2 дахь асуудалтай холбогдуулж Тэмүүжин гишүүн үг авч байна. Микрофоныг нь өгье.

Х.Тэмүүжин: Энэ Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад процедурын хувьд болон ер нь концепцын хувьд 3 үг хэлмээр санагдаж байна. 1 дүгээрт ер нь ажлын хэсэг, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байгаа дэд хэсэг хоёрын дунд нэг нь шийдвэр гаргагч, нэг нь мэдээлэл өгч байдаг 2 зааг байгаа шүү. Тэрийг маш сайн ойлгодог байх хэрэгтэй. Ер нь тэр дундаа хуулийн байгууллагуудтай холбоотой тэдний үйл ажиллагаатай холбоотой зарчмын өөрчлөлтүүдийг хийхэд яг хэрэгжүүлэх гэж байгаа байгууллагаас мэдээллийг нь авч сонсгож болох боловч тэднээр шийдвэр гаргаж ерөөсөө болохгүй. Зоригтой томоохон өөрчлөлт, тэр дундаа иргэний эрх, эрх чөлөөтэй холбоотой дэвшилттэй үзэл санаан дээр манай хуулийн байгууллагууд маш хойрго ханддаг. Өөрсдийнхөө ажлыг яаж хөнгөвчлөх вэ гэдэг тэр тал дээрээ, эсхүл эрх мэдлийг яаж өөр дээрээ төвлөрүүлэх вэ гэдэг тал дээрээ л анхаараад байхаас биш, энэ хуулийн байгууллагуудаас үйлчилгээ авч байгаа тэдний үйл ажиллагаанд өртөж байгаа иргэний эрх, чөлөөний баталгаа яаж хангагдах юм, дэлхий нийт дэвшилттэй ямар өөрчлөлт рүү явчхав гэдэг тал руугаа ер нь жоохон хойрго, зоримог биш байдаг. Тийм учраас ажлын хэсэг дээр энэ сонирхлын зөрчлийг нь тооцож, шийдэл гаргаж байх ёстой гэдэг зарчим руугаа зоригтой явах хэрэгтэй.

2-т нь Улсын Их Хурлын чуулган дээрээс чиглэл өгөөд, боловсруулалтыг нь сайжруулах зорилттой эцсийн чиглэл өгсөн энэ асуудлууд дээр нөгөө санал хураалтынх нь хувилбараар орж ирэхгүй ингээд зүгээр хасчихдаг энэ процесс бол их бүдүүлэг процесс шүү. Яагаад гэвэл шийдвэр гаргагч бол Улсын Их Хурал олонх, цөөнхөөрөө зөв, бурууг л шийднэ. Энэ хуулийг дэмжих үү, дэмжихгүй юу, энэ бодлого зөв үү, буруу юу гэж. Тэгснээс ажлын хэсэг юм уу, ингээд санал хураалтгүй алга болгочхож ерөөсөө болохгүй. Гүйцээн боловсруулах чиглэл авъя гэж чуулган дээр чиглэл авчхаад, тэгээд энүүгээр санал хураагаад хэрэггүй гээд явчихна гэдэг бол чуулганы эрх мэдлийг алга болгож байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхлээр энэ дээрээ дараа дараагийн зүйл дээр жоохон бодно биз.

Гол асуудал юу байсан бэ гэхээр бид анх 24 оны сонгуулийн дараа Улсын Их Хурал эхлээд л хамгийн цочир мэдээ эрүү шүүлтэд өртөж иргэн нас барсан тухай байсан. Эрүү шүүлтэд өртөөд, түүндээ гомдол гаргасныхаа төлөө цагдан хоригдоод, тэгээд гомдол гаргасан байгууллага нь өш хонзонгийн сэдэлтэй юм шиг хуулийг ашигласнаасаа болоод хууль зүйн туслалцаагаа авч чадахгүйгээр залуухан хүн нас барж байсан байхгүй юу. Улсын Их Хурал бөөн юм болсон. Гишүүд зарим нь попорсон, зарим нь асуудлаа шийдэх юм сан гэж санаа зовсон. Хүний эрхийн Үндэсний Комиссын.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн 1 минут.

Х.Тэмүүжин: Хүний эрхийн Үндэсний Комиссын удаа дараагийн илтгэлд Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжүүд, манай Монгол улс НҮБ-ын өмнө авсан амлалт энэ тэр гээд бүх юман дээр энэ эрүү шүүлттэй холбоотой асуудлаа шийдээч. Танайд эрүү шүүлт чинь хуулийн байгууллагуудын чинь соёл болоод байна. Эрүү шүүлттэй холбоотой нотлох баримт дээр түшиглэж шүүгч нь шийдвэр гаргаад байна. Эрүү шүүлтийн үр дүнд гарч байгаа шүүхийн шийдвэр чинь хэзээ ч

шударга байж чадахгүй. Хуулийг дээдлэх гэдэг ангилал руу орохгүй. Тийм учраас энэ асуудлаа төгс шийдээч гэдэг заавар чиглэл Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн санаа зовсон. Тэгээд энэ хуулийн өөрчлөлттэй холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж байгаа юм байна. Тэр тогтоолын төсөл дээр энийгээ гүйцэд шийдвэрлэх тодорхой чиглэл орж байгаа юм байна. Хугацаагаа 9 сарын 1 гэж тавьж байгаа юм байна. Ажлын хэсэг энэ дээр бүр санаачилгатай ажиллана. Хамтарч энэ чиглэлийн өөрчлөлтүүдийг хийхийн тулд нам харгалзахгүйгээр дундын итгэл үнэмшилтэйгээр явъя гэж байгаа учраас бид хэлэлцэхийг нь үргэлжлүүлээд явъя гэдэг байр суурьтай байна.

Ц.Сандаг-Очир: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Батцэрэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч байгаа юу? Байхгүй байна. Б.Энхболд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Я.Цэлмэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн, М.Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Д.Мөнхөө Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, О.Мөнхбаатар УЕП-ын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Л.Данзанноров Монголын өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, С.Түмэн-Од Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, В.Баасанхүү ТЕГ-ын Мөрдөн шалгах газрын тасгийн дарга, Х.Буянтүмэн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, Б.Гантуяа Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн гишүүн, Оростогоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, энэ олон улсууд байгаа юм уу? Сандаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Очбадрах ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа, Батдэлгэр ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дэд дарга, З.Сүхбаатар Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Б.Батзориг Монголын криминологчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга, Д.Батсүх Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хорооны дарга, Т.Энхбаяр Монголын, байхгүй байна тийм ээ? Ийм ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Хурал даргалагч, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 25 оны 6 дугаар сарын 19-ний

өдрийн нэгдсэн хуралдаанаа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үеэр хуралдаан даргалагч хуулийн төслийн зарим хэсэг, заалтыг гүйцээн боловсруулж, холбогдох зүйл, хэсэг заалттай уялдуулан чиглэл өгсний дагуу ХЗБХ-ны 2025 оны 5 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг чиглэл өгсөн 5 асуудлаар 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж, асуудал бүрийг нэг бүрчлэн хэлэлцсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу бэлтгэсэн томьёоллыг Байнгын хороонд танилцуулж байна. Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлт болон шүүхийн шийдвэрийг яллагч, прокурор, оролцогчид бүрэн танилцуулж, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж гардуулж өгөх саналыг тодруулан найрууллаа.

Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссаны дараа дууссан хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзүүлэх, хэргийн оролцогчийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, хавтаст хэргийн материалтай танилцуулах хугацааг 7 хүртэл хоногоор, бусад хэргийн материалыг ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж нөхцөлөөр хангаж, мөн хавтаст хэргийн материалтай танилцах үндсэн хугацаа 14 хүртэл хоног, хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болохоор томьёоллыг танилцуулж байна.

Түүнчлэн шүүгдэгчийн сонгож авсан өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүй ирээгүй, эсвэл шүүгдэгчээс шүүгдэгч өмгөөлөгчөөс татгалзсан тул шүүх хуралдаан журмын дагуу өөр өмгөөлөгчийг оролцуул гэсэн зохицуулалт нь Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд тууштай хамгаалах зарчмыг хөндөж байх тул хуулийн төслөөс уг саналыг заалтыг хасаж байна. Мөн Ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны анхны хэлэлцүүлэг, хавтаст хэргийн цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаан шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэхтэй холбоотой зохицуулалтыг төслөөс хасах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнтэй холбогдон Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Уг тогтоолын төсөлд иргэн, эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн хавтаст хэргийг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагуудын цахим мэдээллийн санг нэгтгэн холбох, цахим системийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар. Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх асуудлыг боловсронгуй болгох талаар, мөн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч цахим хавтаст хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах асуудлыг боловсронгуй болгох талаар, мөн эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус хэрцгий харьцаж тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болохгүй байх зохицуулалтыг судлан олон улсын

гэрээнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар тусгалаа.

Ажлын хэсэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны дарга, хурал даргалагч, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй санал, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн 4 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Улсын Их Хурлын даргаас чиглэл өгсөн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт явуулах гэж байна, саналдаа бэлдээрэй. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зөрүүтэй зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “танилцуулж, төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж,” гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58,8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ.

3 дахь санал хураалт, төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор

санал хураалт явуулъя. 3.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.”” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 4.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг хасаж, мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчид хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хавтаст хэргийн материал танилцуулах хугацаа 7 хүртэл хоногт, бусад хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Авах хэмжээний тогтоол уу? Тийм байна.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, уг ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай.

1/эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн хавтаст хэргийг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагуудын цахим мэдээллийн санг нэгтгэн холбох, цахим системийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2/эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэгсэл ашиглаж, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх асуудлыг боловсронгуй болгох.

3/эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч цахим хавтаст хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах асуудлыг боловсронгуй болгох.

4/Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж, тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болгохгүй байх зохицуулалтыг судлан, олон улсын гэрээнд нийцүүлэн холбогдох хуулийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

5/энэ тогтоолын 1, 2, 3 дахь заалтад заасан үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-т даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна. Тогтоолын төслийн найруулга дээр саналтай байна гэж байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энэ дээр сая нөгөө Тэмүүжин гишүүний хэлж байгаа саналыг бид хүндэтгэж байгаа. Дээрээс нь уг асуудлыг нөгөө Улсын Их Хурлаас гарч байгаа хууль маань өөрөө судалгаа шинжилгээнд үндэслэж гарах учраас энэ талын юмнууд нь дутуу учраас энэ саналыг гүйцээн боловсруулахад бусад заалтууд хөндөгдөх юм байна гээд бид зөрчилдөх ийм санал хураалгах бололцоогүй учраас бас асуудалд хандсан. Өөрөөр хэлбэл эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт тухайн хүнийг яллах нотлох баримтын эх сурвалж болохгүй байх зохицуулалтыг судлан, олон улсын гэрээнд нийцүүлэн холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн энэ заалт дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсний өмнө 2025 оны 9 дүгээр сарын 1-ний дотор гээд, уншчихсан уу, гэж оруулж байгаа шүү тараачихсан дээрээс.

Тэгээд энийг намрын чуулган гэхэд Засгийн газар талаас анхааръя. Дээрээс нь яах вэ зүгээр боломж нь юу байгаа гэхээр Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн захирамжаар байгуулагдсан эрүү шүүлттэй, хүнтэй хүнлэг бус, хэрцгий харилцахаас холбоотой энэ чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хэсэг маань Тэмүүжин гишүүнээр өөрөөр нь ахлуулан ажиллаж байгаа, миний бие ажлын хэсэгтэй байгаа. Энэ дээрээ бид энэ давхар энэ чиглэлийнх нь хууль тогтоомжийг боловсруулахад оролцоод, хамт явъя гэж байгаа. ХЗДХЯ холбогдох хүрээлэнгээрээ судалгаа шинжилгээг дэмжиж ажиллая гэсэн.

Тэгээд агуулгын хувьд би ганц зүйлийг хэлье дээ. Энэ дээр хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага энэ оролцогч байгууллагуудаас агуулгыг бол эсэргүүцсэн байгууллага байхгүй байсан. Хандлагын хувьд бүгд энийг зөв агуулга байна. Харин яаж уялдуулж томьёолох вэ, энэ заалт орсон тохиолдолд аль, аль заалтууд дээр бид тодруулга хийх ёстой вэ гэдэг зүйл дээр л эргэлзээ гарсан гэдэг зүйлийг Тэмүүжин гишүүнд хэлье. Та түрүүн нөгөө хэлэлцэх явцад хандлагын

асуудал байгаа, энийг ойлгохгүй байна гэсэн бол яг таны энэ дэвшүүлж байгаа энэ заалтыг хууль сахиулах болон хэрэгжүүлэх байгууллагууд хэрэглэх байгууллагууд бол бүрэн дэмжиж байгаа шүү гэдэг зүйлийг хэлмээр байна. Тэгээд энэ тогтоолоо гараад, араас нь хэрэгжилтийг нь анх чиглэлд нь хамтраад ажиллая гэдэг зүйлийг танд хэлмээр байна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу, нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Үг хэлэх гишүүн байна уу? Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Ер нь судалгаатай тооцоотой, няхуур хандаж баталдаг хуулиуд бий. Гэхдээ мэдсэн даруйдаа өөрчлөх ёстой хуулиуд байдаг. Тэр дундаа хүний эрхтэй холбоотой, тэр дундаа төр иргэнд өөртөө байгаа хамгийн хүчтэй арга хэрэгслээрээ хүч хэрэглэж, эрүү шүүлт тулгаж байгаа ийм үйл явдлыг засах, сайжруулахтай холбоотой нөхцөл байдал илэрсэн бол энийг судалъя гэж хойш нь тавьдаг ийм төр байж болохгүй уг нь. Мэдсэн даруйдаа, ойлгосон даруйдаа энийг өөрчлөхийн төлөө цаг алдалгүй ажилладаг хууль тогтоогч байх ёстой юм.

Тэгээд харамсалтай нь бид ингээд 9 сарын 1 хүртэл хойшлуулж байна. Улсын Их Хуралд нэг хууль өргөн барьсан байгаа, тэр хуулийн ач холбогдол яагаад чухал вэ гэдэг дахиад энд яригдаж байгаа юм. Улсын Их Хурлыг үнэн зөв мэдээллээр хангах, мэдээллээр хангах үүрэг бүхий тийм чиг үүрэгтэй орж ирж байгаа албан тушаалтнууд энэ үнэн зөв мэдээллээр хангах үүргээ биелүүлэхгүй бол Улсын Их Хурал алдаатай шийдвэр гаргахаас гадна цаг алддаг. Иргэний өмч хөрөнгө, амь нас, эрүүл мэнд гээд олон зүйлээрээ хойшоо тэр цаг алдсан цаг дээр хохирч үлддэг. 9 сарын 1 гэхэд өнөөдрийн энэ оруулах гэж байсан заалттай зөрчилдөж байна гэдэг зүйл, заалт олдохгүй бол ажлын хэсэгт орсон хүмүүс болон ажлын хэсэг ахалсан хүнтэй ярина шүү. Цаана чинь эрүү шүүлтийн үр дүнд ийм хохирол амсаад байна гээд тоо баримттайгаа, кэйстэйгээ Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлтээр гарч ирээд байхад бид энд хуулийн жоохон эргэлзээ байна гээд энэ асуудлаа шийдэж чадахгүй хойшоо тавьж байгаа байхгүй юу. Дэнсэлж байгаа дэнсний чинь 2 тал өрөвдөлтэй харагдаж байгаа юм. Нэг нь иргэний үндсэн эрх Үндсэн хуульд заасан эрүү шүүлтээс ангид байх. Бүр дайны байдал зарласан ч гэсэн энэ эрхийг хөндөж болохгүй шүү гэдэг Үндсэн хуулийн заалттай эрхийн тухай ярьж байгаа байхгүй юу.

Нөгөө талд нь жоохон судалмаар байна, эргэлзээ байна, хууль хоорондын зөрчил үүсэж магадгүй гээд хойш нь тавьж байгаа юм. Дэнслэх юмаа бид зөв дэнслэхгүй бол ийм л юм болдог. Бид 30 жил дэнснийхээ нөгөө талд байгаа иргэний эрхийг энд байгаа төрийн ажлыг яаж хялбар хийх вэ гэдэг хандлагаараа жин даруулж иргэний эрхийг үгүйсгэсээр ирсэн. Дахиад хэлье. Үндсэн хуульд байгаа заалт шүү дээ. Эрүү шүүлтээс ангид байх ёстой гэдэг иргэний энэ эрхийг бид асуудал байна гэдгийг мэдсээр байгаа мөртөө дахиад нэг жоохон судалъя, энийг л хүнд суртал гэж хэлдэг. Энийг л төрдөө хайртай, иргэндээ ээлгүй, албан тушаалын дон гэж ярьдаг байхгүй юу. Тэгээд бидний хандлага ийм л байгаа дүр зураг өнөөдөр харагдаж байгаа байдал нь л ерөөсөө энэ.

Ц.Сандаг-Очир: Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамт

хэлэлцүүлэх горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 17 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 76,5 хувиар санал дэмжигдлээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. 3 дахь асуудал. Эцсийн хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, хуулийн ажлын хэсгийн ахлагч Сайнзориг танилцуулна.

13.31 цаг

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

3 дахь асуудалдаа оръё. Хаана байна вэ, гаргаад ир дээ. 3 дахь асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Гаргаад ир дээ. Саяынх уу, үгүй биз дээ? Н.Отгончимэг Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ч.Дондогмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Н.Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Г.Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх, Ш.Цолмон ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга. Болсон уу? Т.Энхбаяр Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, Б.Болд Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч, Д.Эрдэнэчимэг “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер байна уу? Байхгүй байна.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулна. Номинчимэг гишүүнд микрофон өгье.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны нэгдсэн чуулган хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 6 зарчмын зөрүүтэй санал, 3 найруулгын саналыг гүйцээн боловсрууллаа.

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу 1 зарчмын зөрүүтэй саналыг хууль тогтоомжийн нийцлийг хангах үүднээс боловсрууллаа. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Номинчимэг гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Сайнзориг гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүний микрофон.

Х.Тэмүүжин: Сая тарааж өгсөн материал эхний хэсэг Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйл гээд үндэсний аюулгүй байдал энэ ингэнэ. 17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх гэж бичигдсэн байна. Концепцын хувьд бид 2015 оноос хойш Эрүүгийн хууль дээр хүртэл ингэж бичиж байгаа. Нийгмийн хэв журам гэдэг энэ ойлголтыг нийтийн гэдэг үгээр нь бичиж байгаа. Яагаад гэвэл бид ингээд нөгөө хуулийг хүний эрхийн тал руу нь хэмжихийн тулд, хүнээс ангид хийсвэр тогтолцоо гэхээс илүүтэйгээр нийгмийн биш, нийтийн гээд биччихвэл энэ чинь олон хүмүүсийн дундаа тогтоосон хэв журмын тухай яриа болж хувирч байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм нэг ойлголтуудаа нэг жоохон жигдэлж авахгүй бол үнэхээр ингээд хүнээс салсан ойлголт хамгаалъя гэвэл нэг бол Үндсэн хуулийн дэг журам гэж бичиж байна. Нэг бол үндэсний аюулгүй байдал гэж бичиж байна. Энэ чинь өөрөө хэмжигдэхдээ маш тодорхой байгаад байгаа юм.

Энэ дээр нөгөө нийгмийн гэдэг үгийгээ буцаагаад хэрэглээд ирэхээр Цагдаагийн албаны тухай хууль дээр хүртэл ингэж бичсэн шүү дээ. Нийтийн дэг журам, нийтийн хэв журам гэдэг ойлголтуудыг бичиж байгаа, нийтийн аюулгүй байдал гэж бичиж байгаа. Тэгэхээр энэ нэр томъёоны иймэрхүү юмнуудаа ингээд засахгүй бол бид хэд чинь сая Улсын Их Хурал дээр нөгөө Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөгөө баталчихсан. Хүний эрхийг тойрно, хүн төвтэй хууль тогтоомжийг боловсруулж батална гэдэг ийм нэг зорилт тавьчихсан. Тэгээд хүнээсээ ингээд салдаг, дахиад хэмжихэд төвөгтэй, дараа нь ашиглахад ингээд хууль өргөн барьж байхдаа хүний эрхийн эсрэг концепцоо зөвтгөж болох ийм нэр томъёоны алдаанууд гаргаад байж боломгүй санагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр анхаармаар байна. Үндсэн хууль дээр Үндсэн хуулийн дэг журам гэж байгаа. Зүгээр үгээ дахиад хэлэхэд бид хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо хүнээс гадна хэрэглэгдэж болох, хэмжихэд төвөгтэй субъектив ойлголт хууль руу оруулж

ирээд л байвал нөгөө Үндсэн хуулийн хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм чинь алга болно шүү. Хүн төвтэй, хүн рүү чиглэсэн ийм хэм хэмжээний агуулгуудыг хууль тогтоомжоороо шаардахгүй бол жишээ нь энэний чинь малгай өөрөө юу гэж байгаа вэ гэхээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд гэж байгаад тавих гэж байгаа шүү дээ. Тэгээд хүнийхээ юу гэдэг юм үнэ цэнийг дээр нь гаргаж ирээд, яах вэ бидэнд социалист угшлаараа ийм хийсвэр ойлголтууд тогтолцоо.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүний асуултад Номинчимэг гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

О.Номинчимэг: Тэмүүжин гишүүний асуултад хариулъя. 17.3 дээр яг энэ үндэсний аюулгүй байдал, хүний эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх ёстой гэдэг хүний эрхийг хязгаарлахдаа тавигддаг Үндсэн хуулийн болон олон улсын бидний нэгдэж орсон гэрээ конвенцын үндэслэлийг бичиж байгаа. Тэгээд нэр томъёоны хувьд нийгмийн хэв журам биш, нийтийн хэв журам гэдэг үг рүү яваач гэдэг юмыг хэлж байх шиг байна. Тэгэхдээ бид Үндсэн хуулиа харвал Үндсэн хуулийн 16 буюу хүний эрхтэй холбоотой хэсэг дээр 16.17, 18 энэ дээр яг хүнийхээ эрхийг хязгаарлахдаа аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно гээд энэ үндэслэлүүдийг Үндсэн хуулийн нэр томъёо болгоод оруулчихсан.

Ер нь энэ олон улсын хэллэгтээ public order буюу нийгэм гэж хэлэх юм уу, нийтийн гэж хэлэх юм уу. Тэгэхээр хэрэглээн дээр юун дээр нь алдаа гарах гээд байгааг мэдэхгүй байна. Гэхдээ бид Үндсэн хууль дээрээ энэ хүний эрх, эрх чөлөөгөө хязгаарлахдаа зөвхөн public order буюу нийгмийн хэв журмыг хангахын тулд л ийм хязгаарлалт хийж болно шүү гэдэг хуулийн үндэслэлийг нь тавьчихсан байгаа учраас бид Хууль тогтоомжийн хуульдаа Үндсэн хуулиа баримтлах зарчмыг бариад, энэ нэр томъёогоор явж байгаа гэдгийг тайлбарлаж хэлье.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн тодруулъя.

Х.Тэмүүжин: Саяхан бид нөгөө цагдаагийн албаны олон улсын баримт бичигтэй холбоотой нэг гэрээ орж ирсэн байхгүй юу. Чех улстай байгуулсан шиг санаж байна, Чех билүү, Польш билүү, Европын улстай. Чехтэй тийм ээ. Чех улстай байгуулсан энэ гэрээ дээр public order гэдгийг олон улсын баримт бичгээрээ нийтийн гэж оруулж ирсэн. Тэгээд яагаад гээд цаад талын тайлбар дээрээ бас яг энэ агуулга байсан. Яагаад гэвэл олон хүний аюулгүй байдлыг олон хүн дундаа тохироод дэг журам тогтоож байгаа учраас хэв журмыг хамгаалах зорилготойгоор хууль сахиулах хамтарч ажиллана. Чехийн тал бүр яг ингэж хэлж байгаа байхгүй юу.

Нийгмийн буюу, тогтолцооны буюу улс төрийн дэглэмийг хамгаалах зорилготой хууль сахиулах байгууллага хамтарч ажиллахгүй шүү гэж. Тэгэхээр энэ ойлголт яг сүүлийн энэ 92 оны Үндсэн хуулийн хойших 30 жилийн хугацаанд яаж хөгжиж байна вэ гэхээр хүнээс салгасан ойлголтын төлөө төр татвар төлөгчдийн мөнгийг тавиад, иргэдээс мандатаараа авсан эрх мэдлийг төрд шилжүүлж өгвөл буцаад хүнийх нь дайсан болж хувирдаг юм байна. Хүний эрхийн эсрэг үйл явдал болж хувирдаг юм байна. Тийм учраас хэм хэмжээ тогтоож байгаа бүх зүйл чинь хүний эрхийг хязгаарлах гэж байгаа бол өөртэй нь адилхан олон хүний дундын

итгэл үнэмшил, хэм хэмжээ, тэдний нийтлэг ашиг сонирхлын төлөө хязгаарлалт тавихаас биш, өөртэй нь адилхан хүн биш, хийсвэр нийгмийн зорилгоор хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж болохгүй шүү гэдэг л концепц олон улсын бичиг баримтаар хүртэл орж ирж байгаа шүү дээ. Ийм учраас бид ер нь алдаатай зүйлийг засаад, дэвшилттэй үзэл санааг урагшлуулаад явах ёстой болохоос биш ингээд дахиад механик байдлаар нэр томъёоныхоо дор сөгдөж унаж болохгүй л гэж би хувьдаа харж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Хариулах юм уу? Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энийг үзэл санааны хувьд мэдээж ойлгож байгаа. Бид иргэний, хүмүүнлэг ийм нийгмийг бүтээн байгуулна гээд Үндсэн хууль дээрээ бид энийг тунхаглачихсан. Монгол Улс энэ хүний улс төрийн болон эдийн засаг, нийгмийн эрхийг нь олон улсын фактад нэгдээд орчихсон бүхий л энэ НҮБ-ын хүний эрхтэй холбоотой гэрээнүүдэд нэгдээд орчихсон. Энэ дээр угаасаа энэ ойлголтууд бол манай Монгол Улсад нэгдэж орсон хууль маань энэ чиглэлээр ашиглагдана, хэрэглэгдэнэ гэдэг асуудал нь угаасаа манай хуулиудад суудаг.

Тэгэхээр яах вэ та бүхний нийгмийн, нийтийн гэдгийг ойлгохоос илүүтэй бид угаасаа олон улсын гэрээ хэлэлцээрт орчихсон энэ утгаар ойлгоно гэдгээ Монгол Улс 1992 оноос хойш энийгээ батлан хамгаалчихсан, үзэл баримтлалдаа хамгаалаад явж байгаа учраас энийг нэг зөвхөн үгийн хувьд ийм өөр юм байгаа шүү гээд Үндсэн хуулийнхаа үзэл санаа, нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн хувьд өөр утга санаа байна гэдэг асуудлыг тавьж байгаа нь хэр зохимжтой юм болоо л гэж бодож байна. Тэгэхээр бид Үндсэн хууль дээрээ заасан үгээ, нэр томъёогоо ашиглаж байгаа. Хэрвээ энэ бол ийм байх ёсгүй, үзэл санаа нь ийм байх ёстой гэдэг байгаа бол Үндсэн хууль дээр өөрчлөгдөх ёстой байх. Гэхдээ Үндсэн хуулийн тайлбар дээр яг л бидний олон улсын Нэгдсэн Үндэстний Байгууллагад нэгдэж орсон энэ public order гэдэг утга агуулгаар энэ нийгмийн хэв журам гэдэг үгийг хэрэглэж сурсан гэдгийг, 30 жилийн хувьд хэрэглээг нь онолын хувьд ингэж ойлгох ёстой шүү гэдэг зүйл тогтсон гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Би зүгээр 2, 3 зарчмын юмыг хэлмээр байгаа юм. 1 дүгээрт яах вэ ер нь хууль санаачлагч гишүүн маань өөрөө хурал даргалж болдоггүй юм байна гэдэг зүйлийг би энэ Хууль тогтоомжийн хуулийн хэлэлцүүлгүүдээс харлаа. Аливаа зүйлийг нөгөө хурал даргалах гэхээсээ илүүтэй орж ирсэн төслөө тохируулан тааруулж, тайлбарлах байдлаар гишүүдийн дундах уур амьсгалыг үнэхээр сонин болгосон. Би энийг л хэлж байгаа юм. Тэгэхээр ийм зүйлүүдээр байдаг бол Дэгийн хууль хийгээд, Байнгын хорооны дарга өөрөө магадгүй эсвэл хурал даргалагч гишүүн хуулийн төслөө хэлэлцүүлж байгаа бол өөр гишүүнээр даргалуулчихдаг ч юм уу ийм байхгүй бол юм хэлэхээр л ингээд микрофоны давуу талаар ч юм уу ийм зүйлүүдээс болж энэ маш олон үл ойлголцлууд гарсан байдаг юм. Би энийг ер нь зүгээр цаашдаа бид анхаарах ёстой юм байна гэж үзэж байгаа.

2 дугаарт яах вэ? Энэ ингээд эцсийн хэлэлцүүлгийг засаад ороод ирж байгаад баярлалаа. Тэгээд би өнөөдөр энэ хуулиас болж нэр бүхий гишүүд зарим зүйл дээр ингээд маргаан мэтгэлцээн явсан. Номинчимэг аль болохоор засах гэж зарим саналуудыг авахыг хичээж байгааг би ойлгож байгаа. Тэгэхдээ би нэлээн том гүжирдүүлээ. Чиний санал Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Жаргалан

2-оос илүү байна гэж юу байдаг юм. Ийм байж болохгүй, миний санал биш байхгүй юу. Тэр парламент дэмжээд, энэ төсөлд оруулах ёстой санал гэж байгаа. Би тэгээд техникийг нь засаач гэсэн харин засчихлаа, баярлалаа. Тэгээд би яг энэ санал дээр энэ Хууль тогтоомжийн хууль маань өөрөө эргээд гишүүдийн Үндсэн хуулиар олгосон хууль санаачлах эрхтэй холбоотой хууль юм байгаа юм. Төрийн бодлого шинжлэх ухааны үндэстэй, судалгаатай гардаг байх байгаад байгаа юм.

2 дугаарт би Пүрэвдорж даргын олон дэвшүүлдэг асуудалтай санал нийлдэг. Саяхан Пүрэвдорж дарга амралтын өдрүүдээр Ховдод айлчилж байхдаа орон нутагт байдаг маш олон эрхүүдийг дээшээ татсан байна гэж хэлсэн билээ. Би энийг олзуурхаж байгаа байхгүй юу. Энэ хуулиар олон эрх мэдлүүдийг зөвхөн хууль тогтоогч авах гэж байсныг харин ажлын хэсэг ажиллаад, тодорхой хэмжээнд жоохон балансжууллаа л гэж харж байгаа. Тэгэхдээ эргэлзээтэй зүйлүүд бол байгаа. Тэгээд хэдүүлээ яах вэ тэгээд л хуулийг нэгэнт олонхоороо шийдэж байгаа учраас үндэслэлтэй хандаад, хэрэгжүүлээд үзье. Дараа нь мэдээж хуулийн эерэг, сөрөг нөлөөг дараа нь ярьж болно. Маш олон орон нутгуудад байсан эрх мэдлүүдийг ерөөсөө байхгүй болгох гэж байсан байхгүй юу. Тэгээд бид хэд эрх мэдлийг хэт энд хууль тогтоогч төвлөрүүлээд сайн зүйлд хүрэхгүй. Энийгээ дагаад тэр орон нутагт байдаг чиг үүрэг нь байхгүй болохоор төсөв нь байхгүй болчихдог, хүний нөөц нь байхгүй болчихдог, орон нутагт чинь зүгээр нэг ийм эрх мэдэлгүй л бүтцүүд ажиллаад байх, орон нутгийн иргэдийнхээ асуудлыг шийддэггүй тийм л зүйл рүү орчихдог байхгүй юу.

Тэгээд иргэд маань анхан шатны нэгжээрээ орохоор юм шийдэхгүй байж, юугаа хийж наанаа суугаад байгаа юм гэдэг байдлаар орон нутагт ажилладаг алба хаагчдаа шүүмжилж эхэлдэг. Хөөрхий тэд чинь шийдэх эрх мэдэл нь байхгүй, бид чинь улам дээш нь төвлөрүүлж аваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ингээд балансжуулахыг хичээж байсан ажлын хэсэгт би зүгээр талархаж байгаа юм. Тэгэхдээ эргэлзээтэй маш олон зүйл үлдсэн гэдгийг протоколын хувьд үлдээе. Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газраас яг албан ёсоор хариултаа өг. Энэ хууль дээр гишүүдийн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн 1 минут.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын гишүүдийн дэмжиж оруулсан саналыг яагаад эцсийн хэлэлцүүлэг бэлтгэхдээ оруулаагүй вэ? Энэ алдааг гаргасан уу, үгүй юу гэдгээ хүлээн зөвшөөрч байна уу? Би Сайнзоригтоо биш байхгүй юу. Сайнзоригийг дарж нухчихын тулд хураалгаагүй саналыг бид ярьж байгаа учраас чиний саналыг тусгачихгүй гэдэг ийм дэг хаана байдаг юм бэ? Тэгээд энэ дээр ийм техникийн алдаа гаргасан, гаргаагүй гэдгээ яг хариуцлагатай микрофонд үлдээгээдэх. Энэний цаана энэ заавар зөвлөгөөгөө өгдөг хүмүүс, мэргэжлийн арга зүйгээр хангаж байгаа хүмүүсийн асуудал яригдана шүү.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүний асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Дондогмаа дарга хариулна. Ажлын хэсгийн 1 дэх микрофон.

Ч.Дондогмаа: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх явцад бол төслийн 17.3 дахь хэсэгтэй холбоотой 3 гишүүнээс санал гарсан 17.3 дахь хэсэгтэй холбоотой. Мөн чуулганы нэгдсэн хуралдаанаар 17.3 дахь хэсэгтэй холбогдуулаад 2 асуудлаар

гүйцээн боловсруулах чиглэл авсан. Тэгээд 17.3-ыг уялдуулж, гишүүдийн саналыг тусгаад болон гүйцээн боловсруулах чиглэл авсан саналуудыг томьёолж оруулж ирэхдээ 17.3 дахь хэсгийг хэвээр үлдээнэ гэж тооцоолоод томьёоллоо бэлдчихсэн байна.

Ц.Сандаг-Очир: Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Та өөрөө асуусан асуултаа сонсохгүй юм хариултаа. Санал хураалт гишүүдээ, одоо 8-хан санал байгаа. Хариуцлагатай яагаад гялс санал хураалтаа дуусгахгүй бол чуулган эхлэх болж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу санал хураалгах, санал хураалгая.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтад анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн болон гүйцээн боловсруулах чиглэл авсан саналыг тусган, доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмэх:

“17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-д заасан үнэлгээнд нэмж тусгана:

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

17.3.2.ялгаварлан гадуурхахгүй байх;

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” Санал хураалт. 2/3-оор юм байна шүү. 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар дэмжигдлээ. Хэд болсон бэ? Алтанхуяг гишүүн горимын санал гаргая.

Н.Алтанхуяг: Уучлаарай, би нөгөө бие засаад ирсэн чинь ингэж хэж, тэгээд дахиад санал хураагаад өгөөч.

Ц.Сандаг-Очир: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын санал гаргасан байна. Гишүүдээ санал хураалтдаа анхааралтай хандаарай, 2/3-оор дэмжигдэх ёстой. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт. 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 17 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 76,5 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ хуулийн 12.1.2, 12.1.3,

12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй.” Санал хураалт. 17 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 76,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлээр ажилладаг хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх. Сайнзориг гишүүн санал.

П.Сайнзориг: Энэ санал ер нь зүгээр зөв байгаа юм. Тэгэхдээ нөгөө нэг Энхтүвшин гишүүн бүр дагнан ажилладаг гэж орж ирээд, ажлын хэсгээ сайжруулж байгаа юм. Тэгэхээр би энийг ажлын хэсэг маань зөвшөөрч өгвөл чиглэлийн хүн, хуулийн этгээд л гэхчхмээр байна. Судалгааны чиглэлийн хүн, хуулийн. Чиглэлийн ажилладаг гэхээр ажилладаг гэдгийг хэрхэн яаж нотлох вэ гэж байна. Тэгэхээр энэ чиглэлийн зардлыг төрийн байгууллагаас гарчихаар аудит яг ажилладаг хүнээр хийлгэсэн, хийлгээгүй гээд л нотлох баримтууд шаардаад ингээд төрийн байгууллага бие биеэ хүртэл яг нэг ийм юмаар ороодог юм. Тэгэхээр та хэд маань энийг зөвөөр ойлгоорой. Найруулга байхгүй юу. Тэгэхээр чиглэлийн хүн, хуулийн этгээд ч гэдэг юм уу ингэжхээрэй. Энийг тэгээд би протоколд үлдээчихье. Тэгээд чиглэлээр ажилладаг гэхчхээр ажилладаг эсэхийг нь тогтоох хүн нэг юм гарч ирнэ, хэн тогтоох вэ гээд л.

Ц.Сандаг-Очир: Найруулгын санал хэлж байна. Судалгаа шинжилгээний байгууллага, судлаач гэснийг хууль зүй, төсвийн судалгааны чиглэлийн хүн, хуулийн этгээд гэж өөрчлөх. Найруулгын санал, санал хураалт. 17 хүнээс 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.3.6.асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх” Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 76,5 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.6.Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой хувилбарыг, үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.” Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал. Найруулгын 3 санал байна гишүүдээ. 1.Төслийн 2 дугаар зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэсний өмнө “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө “33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-д” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж,” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, “40 дүгээр зүйлийн”

гэсний өмнө “39.4 дэх хэсгийн “39.3-д” гэснийг “39.3, 39.4-т” гэж,” гэж 5 дугаар зүйлийн “12.2.1,” гэсний дараа “12.2.17” гэж, мөн төсөлд “6 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн зүйл нэмэх. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ. Отгонбаяр гишүүнийг дэмжсэнд протоколдоорой.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг, 2 дугаар зүйлийн ““39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “39.3” гэсний дараа “, 39.4” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “энэ хуулийн 41.3” гэсний дараа “, 41.4” гэж,” гэснийг 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэснийг “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж хавсаргана” гэж,” гэснийг, “мөн зүйлийн 41.4, 41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10 дахь хэсгийн дугаарыг “41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10, 41.11” гэж, 41.5 дахь хэсгийн “41.4-т” гэснийг “41.5-д” гэж, 41.7 дахь хэсгийн “41.5-д” гэснийг “41.6-д” гэж,” гэснийг, мөн зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг, 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2,17, 12.2.24 дэх заалтыг,” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч О.Номинчимэг танилцуулна.

14.01 цаг

Өнөөдрийн ХЗБХ-ны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаандаа оролцсон гишүүддээ баярлалаа. Хуралдаан дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

